



ХҮН

ХУДАЛДААЛАХТАЙ

ТЭМЦЭХ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЙЛАН

2022-2023





World Vision


The Asia Foundation

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЙЛАН

(2022-2023 ОН)

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА	3
Товчилсон үгийн жагсаалт	4
Зураг, хүснэгтийн жагсаалт	5
МЭДЭГДЭЛ	6
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ	7
Бүлгийн дүгнэлт	20
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	21
2.1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	22
2.2.Хохирогч хамгаалал	34
2.3.Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	40
2.4.Хамтын ажиллагаа	46
Бүлгийн дүгнэлт	50
ЗӨВЛӨМЖ	55



ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департамент хооронд “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийг дөрөв дэх жилдээ хэрэгжүүлж байна.


Төслийн зорилго нь хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогч төвтэй арга барилыг нэвтрүүлэх, гэмт этгээдүүдэд зохих ял шийтгэл оногдуулж, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж чадавхыг бэхжүүлэхэд оршино.

Төслийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох явцыг сайжруулах, үйл ажиллагааг уялдуулах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах тогтолцоог бэхжүүлэх зорилгоор мэдээлэлд суурилсан “Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдал”-ын тайланг жил бүр боловсруулж, холбогдох талуудад түгээхээр төлөвлөсөн.

Энэ хүрээнд “Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайлан” 2017-2021 судалгааны анхны тайланг 2022 онд боловсруулан Хүн худалдаалахтай тэмцэх дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн баталгаажуулж байсан бол энэ удаагийн тайланг дээр дурдсан төслийн хүрээнд байгуулагдсан Салбар дундын хамтарсан баг (СДХБ)-аас боловсрууллаа.

Өмнөх судалгааны тайлан нь 5 жилийн хугацааг хамарсан, олон талт мэдээллийг багтааж байсан бол энэ удаад бид 4Р буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хохирогч хамгаалал, урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны түвшний хүрээнд мэдээлэлд суурилсан, товч бөгөөд тодорхой дүгнэлт, санал, зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргэхийг зорьсон болно.

Зураг 1. Судалгааны арга зүй



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХЯ	Гадаад харилцааны яам
ИНҮТ	Иргэний нисэхийн үндэсний төв
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
ОУНБ	Олон улсын нисэх буудал
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
Палермогийн протокол	Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол
ТББ	Төрийн бус байгууллага
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХТК	Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам



ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Шүүхээс оногдуулж буй ял, түүний интервал	32
Зураг 1.	Судалгааны арга зүй	3
Зураг 2.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ	13
Зураг 3.	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	15
Зураг 4.	Хүүхдийн ёс суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх ажил	18
Зураг 5.	Хүүхдийг хүчирхийлэлд өртүүлэх магадлалтай ажил	18
Зураг 6.	Прокурорын байгууллагын статистик	22
Зураг 7.	Яллагдагчаар татсан хүний тоо	24
Зураг 8.	Яллагдагчаар татагдсан этгээдүүдийн насны байдал	25
Зураг 9.	Яллагдагчаар татагдсан хүмүүсийн боловсрол, мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн байдал	25
Зураг 10.	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын байршил	27
Зураг 11.	Гадаад улсад хохирсон хүний тоо	27
Зураг 12.	Хохирогчийн хүйсийн мэдээлэл	28
Зураг 13.	Хохирогчдын насны байдал	28
Зураг 14.	Хохирогчдын боловсролын түвшин	29
Зураг 15.	Шүүхэд шилжүүлсэн хэргийн шийдвэрлэлт	31
Зураг 16.	Үйлчилгээ үзүүлж буй байгууллагад хандсан хохирогчийн тоо (хүйсээр)	34
Зураг 17.	Мөлжлөгт өртсөн хэлбэр	35
Зураг 18.	Түр хамгаалах байранд байрласан хохирогчдын тоо (2022-2023)	35
Зураг 19.	2022-2023 онд Хүйсийн тэгш эрх төв ТББ-д хандсан үйлчлүүлэгч/хохирогчдод үзүүлсэн үйлчилгээний тоон үзүүлэлт	36
Зураг 20.	2022-2023 онд Талита Ази-д хандсан үйлчлүүлэгч/хохирогчдод үзүүлсэн үйлчилгээний тоон үзүүлэлт	37
Зураг 21.	Гэрээр айлчлагч хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талууд	42
Зураг 22.	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	42
Зураг 23.	Хөх зүрхний аян болон Мэддэг мэдээлдэг байя аян	43
Зураг 24.	Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд	46

МЭДЭГДЭЛ

Энэхүү “Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайлан (2022-2023)”-г Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департамент хооронд байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах” төслийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэв.

Тайланд дурдагдсан үзэл бодол, үр дүн, мэдээлэл, дүгнэлт нь зөвхөн зохиогчийнх бөгөөд Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

СУДАЛГААНЫ БАГ

Ж.АРИУНАА

Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор бөгөөд Салбар дундын хамтарсан багийн гишүүн;

Г.ЗОЛЗАЯА

Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор;

Г.АМАРЖАРГАЛ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн бөгөөд Салбар дундын хамтарсан багийн ахлагч;

Ж.ТӨМӨРБАТ

Дорноговь аймгийн Цагдаагийн газрын Замын-Үүд сум дахь Цагдаагийн хэлтсийн дарга бөгөөд Салбар дундын хамтарсан багийн гишүүн, цагдаагийн дэд хурандаа;

Т.ЦОГЗОЛМАА

Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллагын хөтөлбөрийн ажилтан бөгөөд Салбар дундын хамтарсан багийн гишүүн.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ



**ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ
ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ
АСУУДАЛ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Хууль тогтоомж, шүүхийн шийдвэрийн бичвэр, үг хэллэг нь монгол хэл бичгийн дүрэмд нийцсэн, товч тодорхой, салаа утгагүй, ойлгоход хялбар байх ёстой. Хууль энэ шаардлагыг хангасан байх талаар Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3¹, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 36.2.3² дахь хэсэгт тодорхой заасан.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд хүн худалдаалах гэмт хэргийн талаар “Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Гэвч хүн худалдаалах гэмт хэргийн хэлбэр бүрийг өөр зүйлд бие даасан гэмт хэрэг болгож зохицуулсан нь хуулийн зүйл, заалтын давхардал үүсгэж, энэ нь хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй, тодорхойгүй байдал үүсгэж байна гэж олон судалгааны тайланд дурджээ³.

Эрүүгийн хууль нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой бол эрүүгийн хариуцлага нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх,

¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйл.Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага

30.1.Хуулийн төслийн хэл зүй, найруулга дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;

30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;

30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;

30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;

30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.

² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийн хэлбэр, бүтэц

1.Монгол Улсын нэрийн өмнөөс гаргах шүүхийн шийдвэр нь шийтгэх, эсхүл цагаатгах хэлбэртэй байна.

2.Шүүхийн шийдвэр нь удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгээс бүрдэнэ.

3.Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна.

³ ХЗДХЯ, ГХУСАЗЗАА, Дэлхийн зөн-Монгол ОУБ, Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн суурь судалгаа, УБ.,2021

НҮБ-ын Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага, Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлийн үнэлгээ, суурь судалгаа, УБ.,2021

ГХУСАЗЗАА, Азийн сан ОУБ, Хүйсийн тэгш эрх төв ТББ, Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, УБ.,2022



гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх зорилготой.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлага нь үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна гэж хуульчилсан.

Мөн Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй бөгөөд хуульд заасан нэр томъёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална⁴ гэжээ.

Монгол Улс хүн худалдаалах болон түүнтэй төсөөтэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалах чиглэлээр НҮБ болон түүний байгууллагуудаас баталсан 15 орчим бичиг баримтын 12-т нь нэгдэн орсон байна⁵.

Үүнээс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын гол бичиг баримт нь 2000 оны 11 дүгээр сарын 15-нд батлагдсан, манай улс 2008 оны 5 сарын 16-нд нэгдэн орсон “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц” болон түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол” (цаашид Палермогийн протокол гэх) юм⁶.

Протоколын 3-р зүйлд “хүн худалдаалах” гэдэг нь “хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдэл”-ийг хэлнэ.

“Мөлжих” гэдэгт наад зах нь бусдын биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгоно. Дээр дурдсан аргуудын аль нэгийг ашигласан байх тохиолдолд хүн худалдаалах хэргийн хохирогч өөрийг нь мөлжих гэж байгааг өөрөө зөвшөөрснийг хэрэгсэхгүй гэжээ.

Мөн мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр хүн худалдаалах гэмт хэрэгт тооцохоор заажээ.

Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд Хүн худалдаалах гэмт хэргийг хуульчлахдаа протоколын агуулгыг нарийвчлан тусгаж, зөрчилдөөнгүй болгосон нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн нэг том алхам болсон гэж судлаачид бүтээлдээ дурдсан байдаг.

⁴ Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ., 2016, №7, 1.2 дугаар зүйлийн 4 дэх заалт.

⁵ <https://mfa.gov.mn/%d1%85%d2%af%d0%bd%d0%b8%d0%b9-%d1%8d%d1%80%d1%85%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%be%d0%bb%d0%be%d0%bd-%d1%83%d0%bb%d1%81%d1%8b%d0%bd-%d0%b3%d1%8d%d1%80%d1%8d%d1%8d>

⁶ Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>

Гэвч Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийн төрөл хэлбэрүүдийг “бага” ялтайгаар бие даасан гэмт хэрэг болгон давхар зүйлчилсэн явдал арилаагүй байгаа талаар дээр дурдсан (эшлэл 3) судалгаануудад дурдсан байна. Тухайлбал,

- 12.3 дугаар зүйлд Бэлгийн мөлжлөг,
- 13.13 дугаар зүйлд Албадан хөдөлмөрлүүлэх,
- 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах,
- 16.4 дугаар зүйлд Хүүхдээр гуйлга гуйлгах
- 16.6 дугаар зүйлд Хүүхэд худалдах
- 16.8 дугаар зүйлд Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах
- 16.8 дугаар зүйлд Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах
- 16.10 дугаар зүйлд Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх зэрэг болно.

Ийнхүү зохицуулсан зохицуулалт нь хуулийн давхардал үүсгэж, энэ нь хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй, тодорхойгүй байдал үүсгэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагыг хангахгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ.

Хүн худалдаалах ба бэлгийн мөлжлөг:

Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн үндсэн бүрэлдэхүүнд Хүн худалдаалах гэмт хэргээс ялгах шинжийг “зорчих эрхийг хязгаарлахгүйгээр” гэж томъёолсон. Гэвч Палермо протоколд ч Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд ч хүн худалдаалах гэмт хэргийг зорчих эрхийг хязгаарлаж үйлддэг талаар заагаагүй.

Мөн 12.3 дугаар зүйлийн 12.3.2, 12.3.4 дэх хэсэгт хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор гэж заасан мөн хүн худалдаалах гэмт хэргийн “мөлжих” зорилготой давхардуулж, өрсөлдүүлсэн хэм хэмжээ бий болгосон. Тодруулбал Улсын дээд шүүхийн 2008 оны 12 дугаар тогтоолоор Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарласан бөгөөд уг тайлбарын 1.2 дахь хэсэгт “Ашиг олох зорилгоор” гэж хүн худалдаалах замаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого бий болгохыг хэлнэ” гэж заасан. Мөн тайлбарын 2.1 дэх хэсэгт “Биеийг нь үнэлүүлэх” гэж хохирогчийн хүсэл зоригоос гадуур түүнийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ гэжээ.

Хүн худалдаалах ба албадан хөдөлмөрлүүлэх

Улсын дээд шүүхийн тайлбарын 1.2 дахь хэсэгт “Ашиг олох зорилгоор” гэж хүн худалдаалах замаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого бий болгохыг хэлнэ” гэж, 2.2 дахь хэсэгт “Албадан хөдөлмөр хийлгэх” гэдэгт хүний хүсэл зоригоос гадуур түүгээр аливаа ажил үйлчилгээг төлбөргүйгээр гүйцэтгүүлэхийг хэлнэ.

Өөрөөр хэлбэл аливаа ажил үйлчилгээг хүчээр, хүч хэрэглэхээр заналхийлж, эмзэг байдлыг нь далимдуулж цалин хөлсгүйгээр эрхлүүлсэн нь мөлжих зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнд тооцогдохоор тайлбарлажээ.



Хүн худалдаалах ба хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах

Дээрх тайлбарын 1.2 дахь хэсэгт “Ашиг олох зорилгоор” гэж хүн худалдаалах замаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого бий болгохыг хэлнэ” гэж, 1.12 дахь хэсэгт “Эрхшээлдээ байгаа” гэдэгт эд хөрөнгийн болон бусад нөхцөл байдлын улмаас тухайн этгээдээс хараат байхыг ойлгоно, 2.5 дахь хэсэгт “Эд эрхтнийг нь авч ашиглах” гэдэгт хүний цус, нөхөн үржихүйн эдээс бусад эд эрхтнийг ашиг олох зорилгоор, хууль бусаар авсан үйлдлийг хамааруулж үзнэ.

Эндээс харвал Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргийг заахдаа “хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж хүний цусыг, эсийг, эд, эрхтнийг авсан” гэсэн Хүн худалдаалах гэмт хэргийн шинжтэй давхардуулсныг харуулж байна.

Хүн худалдаалах ба хүүхдийн эсрэг гэмт хэрэг

Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт Хүүхдийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан нь нэг талаасаа Хүүхдийн эрхийн конвенц, түүний нэмэлт болох Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протокол, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 182 дугаар конвенцын хэрэгжилтийг хангах, хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн сайшаалтай хэдий ч хуульд дурдсан зохицуулалтууд нь хүн худалдаалах гэмт хэргийн шинжийг агуулж байгаа юм.

Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протоколын 2 дугаар зүйлд:

(а) **хүүхдийг худалдах** гэж аливаа этгээд буюу бүлэг этгээд **шан харамж буюу бусад аливаа төлбөр авч хүүхдийг бусад этгээд буюу бүлэг этгээдэд шилжүүлэн өгөх** аливаа үйлдэл буюу хэлцлийг хэлнэ;

(б) **хүүхдийн биеийг үнэлэх** гэж **шан харамж буюу бусад аливаа төлбөрийн хэлбэрээр хүүхдийг бэлгийн харилцаанд ашиглахыг** хэлнэ;

(с) **хүүхдийг садар самуунд сурталчлах** гэж хүүхдийг **ил тод бэлгийн харилцаанд бодитоор буюу хиймлээр оруулж байгааг аливаа арга хэрэгслээр илэрхийлэх** буюу гол нь бэлгийн харилцааны зорилгоор **хүүхдийн бэлэг эрхтнийг аливаа байдлаар харуулахыг** хэлнэ.

Мөн протоколын 3 дугаар зүйлд зааснаар оролцогч улс бүр эрүүгийн болон гэмт хэргийн талаарх хуульдаа дор хаяж дараах үйлдэл болон үйл ажиллагааг бүрэн хамааруулж, эдгээр гэмт хэрэг улсын дотоодод буюу үндэстэн дамнасан болон ганцаарчилсан буюу зохион байгуулалттай хэлбэрээр үйлдэгдсэнийг харгалзахгүйгээр хариуцлага хүлээлгэх талаар заахыг дурдсан.

Хүүхдийг аливаа арга хэрэгслээр дараах зорилгоор санал болгох, шилжүүлэх буюу авах гэдэгт бэлгийн хүчирхийлэлд ашиглах, шан харамж авч хүүхдийн эрхтнийг шилжүүлэх, хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхэд ашиглах, хүүхэд үрчлэх үйл ажиллагаанд зуучлахдаа хүүхэд

үрчлэх тухай олон улсын эрх зүйн баримт бичгийн заалтыг зөрчиж хууль бус арга хэрэглэн зөвшөөрүүлэх, хүүхдийн биеийг үнэлэх зорилгоор хүүхдийг санал болгох, авах, шилжүүлэх болон өгөх; хүүхэд оролцсон садар самуун сурталчилгааг үйлдэх, түгээх, тараах, импортлох, санал болгох, худалдах буюу хадгалах үйлдлийг эрүүгийн хууль тогтоомждоо тусгасан байх талаар заажээ.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 182 дугаар конвенцын 3 дугаар зүйлд зааснаар “хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр” гэдэгт:

- ✓ боолчлолын бүх хэлбэр болон **хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх**, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд ашиглах зорилгоор хүчээр буюу албадан оролцуулах зэрэг боолчлолтой төстэй дараах үйл ажиллагаа хамаарна:
- ✓ **хүүхдийг биеэ үнэлэх, садар самуун сурталчилгааны үйлдвэрлэл буюу садар самуун үзүүлбэрт ашиглах, зуучлах, санал болгох;**
- ✓ олон улсын холбогдох гэрээнд тодорхойлсноор **хүүхдийг** мансууруулах бодис үйлдвэрлэх, **хил дамжуулан худалдах** зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, зуучлах, санал болгох;
- ✓ ажлын шинж чанар, түүнийг гүйцэтгэх нөхцөл нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх ажил гэж тодорхойлсон.

Энэхүү Конвенцыг соёрхон баталсан гишүүн улс бүр хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг хориглох, устгахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ нэн даруй авч хэрэгжүүлэх тухай заажээ.

Олон улсын гэрээ, конвенцуудад ийнхүү аливаа үйлдлийг эрүүгийн хуульдаа тусгасан байхаар заасан нь үйлдэл тус бүрийг заавал бие даасан гэмт хэрэг байхаар зохицуулах гэсэн утга санаа биш юм.

Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн аль нэг зүйл хэсэгт зааснаар зохицуулах боломжтой талаар судлаачид бүтээлдээ дурджээ.

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй” буюу **хүүхдийн биеийг нь үнэлүүлсэн, хүүхдийг бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулсан, боолчилсон, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгасан, хүүхдийн эд, эрхтнийг авсан, хүүхдийг албадан хөдөлмөрлүүлсэн** бол хүн худалдаалах гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт заасан Хүүхдээр гуйлга гуйлгах, Хүүхэд худалдах, Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх үйлдлийг хуульчлахдаа гэмт хэргийн субъектив талын шинж болох гэмт хэргийн зорилгыг тодорхой заагаагүй ч энэ нь заавал хүн худалдаалах гэмт хэргээс тусдаа байх шаардлагатай гэсэн үг ч бас биш юм.

Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийн төрөл хэлбэрийг ийнхүү хуульчилсан явдал нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нотлох баримтыг тал



бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох, хэргийн бодит байдлыг нотлохын тулд мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтоох зарчмын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Манай улс Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний нэмэлт болох Хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд нэгдэн орсон. Конвенцын хэрэгжилтийг хангах, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хүчин чармайлт гаргаж, 2012 онд Улсын Их Хурлаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг баталж, өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийхээр зохицуулсан. Ийнхүү хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийхдээ тухайн хуулийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хуульд бүхэлд нь эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтыг сонгож болно гэж заасан.

Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментын хооронд байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төсөл”-ийн хүрээнд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж гүйцэтгэжээ.

Хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, улмаар хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй ололтыг бататгах, хийдэл, давхардлыг арилгах, мөн хуулийг даган гарсан журам, стандартын хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, түүнд тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх, цаашид анхаарах асуудлыг тодорхойлох, улмаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр бодлогын дүгнэлт, санал, зөвлөмжийг гарган оролцогч талуудад хүргүүлэх нь энэхүү үр дагаврын үнэлгээний гол зорилго байжээ.

Зураг 2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ



Хууль тогтоомжийн тухай хуулийн хүрээнд хийсэн үнэлгээгээр хуулийг бүхэлд нь үнэлэхэд, зорилгод хүрсэн байдал 93.8 хувь, практикт нийцэж байгаа байдал нь 31.3 хувь, хүлээн зөвшөөрөгдсөн байдал нь 6.3 хувийн хэрэгжилттэй байгаа үр дүн гарсан⁷.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний үр дүнг тоймлон авч үзвэл:

1. НҮБ-ын “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц болон түүний нэмэлт протоколд Монгол Улс 2008 онд нэгдэн орсон боловч албан ёсоор Төрийн мэдээлэл сэтгүүл болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд нийтлээгүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж, иргэдийн мэдээлэл авах боломжийг хязгаарлаж байгаад анхаарах шаардлагатай гэж,
2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар тусгайлан журам батлах эрх олгосон субъектүүд тэдгээр журмыг өнөөдрийн байдлаар батлаагүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байдлыг бий болгосон байна. Тухайлбал, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхэд хамаарах “Хохирогчийн нэр төр аюулгүй байдлыг хангах журам”, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хувьд “Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам” зэргийг батлаагүй,
3. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд хохирогчийг хэрхэн тогтоох, хохирогчид хэрхэн туслалцаа үзүүлэх асуудлыг шийдвэрлэх нь чухал юм. Гэтэл Монгол Улсын хувьд хохирогч гэх ойлголтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиудаар ялгаатай байдлаар хуульчилсан нь хууль хэрэглээний хувьд төөрөгдөл үүсгэсэн зохицуулалт болсон,
4. Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хамгаалах байрны хувьд Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 58 дугаар тогтоолоор баталсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандартаар зохицуулж байгаа боловч тус стандартад нийцсэн хамгаалах байр байхгүй, хилийн чанадад хэрхэн энэ асуудлыг шийдэх төсвийн асуудлыг шийдвэрлээгүй,
5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Дэд зөвлөл нь хуулиар олгосон бүрэн эрхийн 50 хүрэхгүй хувийг хэрэгжүүлж ажилладаг. Шалтгаан нь тус бүрэн эрхийг хэрэгжүүлэх, хянах, зөвлөх эрх мэдэл бүхий Дэд зөвлөлийн гишүүд нь бие даасан төрийн байгууллагуудын төлөөлөл бөгөөд төрийн тогтолцооноос тусдаа институт учир өөрийн гаргаж байгаа шийдвэрээ хэрэгжүүлэх төсөвгүй, дэд бүтэцгүй, шийдвэр нь заавал биелэгдэх шинжгүй тул бусад байгууллагын тайлан мэдээг сонсох төдийгөөр хүн худалдаалахтай тэмцэх ажлыг хэрэгжүүлж байна,

Хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээгээр гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн байгууллагуудын хэрэгжүүлж буй арга хэмжээ, чиг үүрэг нь хангалтгүй түвшинд үнэлэгдсэн бөгөөд хуулиар тусгайлан журмаар зохицуулахаар заасан журмыг батлаагүй нь хууль практикт хэрэгжих боломжгүй байдлыг бий болгосон. Түүнчлэн хууль хоорондын уялдаа холбоо, хийдлийг арилгаагүйгээс хоорондоо өрсөлдөх хэм хэмжээг бий болгох, хуулиар олгоогүй эрх

⁷ ГХУСАЗЗАА, Азийн сан, Хүйсийн тэгш эрх төв ТББ, Хөгжлийн эрх зүйн төв ТББ, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, УБ.,2023.



хэмжээг журмаар зохицуулсан зэрэг нөхцөл байдал бий болсон. Энэ нь Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх нэгдсэн бодлого, төлөвлөлтгүй байгаатай холбоотой байна гэжээ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд энэ хуулийг дагаж гарсан журмын хэрэгжилт хангалтгүйн зэрэгцээ, зарим хэм хэмжээ тогтоосон актыг огт батлуулаагүй байгааг дурдсан.

Харин Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/399 дугаар тушаалаар Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг баталж, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулжээ⁸.

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Улсын Их Хурлаас Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 148 дугаар тогтоолоор Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан.

Тус хөтөлбөрийн зорилго нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэргийн хохирогчийг хамгаалах цогц үйлчилгээг бий болгох, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдэж байсан⁹.

Үндэсний хөтөлбөрийг 2017-2021 онд 4 зорилт, 26 үйл ажиллагааны хүрээнд төлөвлөн хэрэгжүүлсэн.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд 2022 онд үнэлгээ хийсэн бөгөөд ерөнхий үнэлгээ 91.9 хувьтай гарсан дунд хугацааны үнэлгээнээс 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 3. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

81.9 %



Дунд хугацааны
үнэлгээ

91.9 %



Эцсийн
үнэлгээ

⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960401440661>

⁹ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолын хавсралт, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, 2.1 дэх заалт

Хөтөлбөрт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 26 үйл ажиллагааны 13 нь үр дүнтэй, 11 нь тодорхой үр дүнтэй, 2 нь эрчимжүүлэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудыг нэгдсэн мэдээллийн сүлжээгээр холбож, шаардлагатай техник хэрэгсэл, мэргэжилтнээр хангах”, “Хүн худалдаалах гэмт хэргийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх төвийг байгуулах” гэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна¹⁰.

Хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарах ялын бодлогод орсон зарим өөрчлөлт

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн чуулганы хуралдаанаас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, нэмэлт, өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тусгасан байна.

Уг нэмэлт, өөрчлөлтөөр:

1. Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ;
2. Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалт, 13.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохгүй;
3. Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалт, **13.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт** заасан гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй гэж тус тус нэмсэн байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж илрүүлэх эрх зүйн орчин

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгааллын чиглэлээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, хэм хэмжээ тогтоосон актад энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг таньж илрүүлэх асуудлыг зохицуулалтгүй орхисон байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг тодорхойлж чадаагүйгээс мөлжлөгт өртсөн хэвээр байж, авах ёстой тусламж, хамгаалалтаа авч чадахгүйгээс гадна гэмт хэрэгтнүүдийг шүүхэд шилжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, нотлох баримт цуглуулж чадахгүйд хүрдэг.

Иймээс хохирогчийг илрүүлэн таньж мэдэх нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдүүдийг яллах, хохирогчдод нэн шаардлагатай туслалцаа үзүүлэх, тэдний аюулгүй байдлыг хамгаалах үйл явцын чухал хэсэг юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас БНСУ-ын Гэр бүл, жендэрийн тэгш эрхийн яамтай 2019-2023 онд хэрэгжүүлсэн “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгийн хохирогчид туслалцаа үзүүлэх төслийн хүрээнд #анх удаа нийгмийн хамгааллын салбарт хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж, илрүүлэх заавар,

¹⁰ ГХУСАЗЗАА, Эс Ай Си Эй Судалгааны хүрээлэн, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, УБ.,2022



асуумжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/57 дугаар тушаалаар баталсан байна.

Цаашид хууль сахиулах, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяат, салбарын хяналтын зэрэг төрийн анхан шатны нэгжийн эрх бүхий албан хаагч, мэргэжилтнүүдэд зориулсан эрх зүйн баримт бичигтэй болж, түүнийг амьдралд хэвшүүлэх нь нэн чухал асуудал болж байна.

Таньж илрүүлэх, мэдээлэх холбон зуучлахтай холбоотой эрх зүйн зохицуулалт хангалтгүй байдаг. Хил дээр хэн нэгнийг хохирогч, эсвэл хохирогч болох эрсдэлтэй байна гэж үзвэл хаашаа хэнд хандаад хаана ямар үйлчилгээ үзүүлэх эсэх нь тодорхойгүй байгаа. Ялангуяа нисэх дээр зорчигч бүртгэлийн ажилтан ийм эрсдэлтэй хүнийг илрүүлээ (хараахан хохирогч болоогүй бол) гэхэд цагдаадаа хэрхэн мэдээлэх, цагдаа нь ямар нөхцөлийг үндэслэн эрсдэлтэй гэж үзэх гэх мэт асуудал тодорхойгүй. Замын-Үүдэд эрсдэлтэй гэж үзсэн тохиолдлыг илрүүлэн мэдээлэл өгч зорчигчийг аяллаа зогсооход нь тусалж байгаа боловч цаад зохион байгуулж этгээдийн талаарх мэдээллийг зорчигчоос асууж аль болох дэлгэрэнгүй байдлаар цагдаад өгөхийг хичээдэг. Гэвч ийм мэдээллээр цагдаа цаашид шалгах үндэслэлтэй эсэхийг мэдэхгүй байна. Хохирогчийг тогтоохоос өмнө үйлчилгээ үзүүлэх, хамгаалах үндэслэл үүсэхгүй болохоор хохирогч болох эрсдэлтэй явж байгаа хүнийг анхаарч зогсооход эрх зүйн хувьд болохгүй байх шиг.

Анбаунд Монгол ТББ-ын мэдээлэл

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы хуралдаанаар Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Хуулийн 142 дугаар зүйлд насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг зохицуулсан бөгөөд мөн зүйлийн 142.9 дэх хэсэгт “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг ажил олгогч, ажилтны эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг төлөөлөн хамгаалах үндэсний байгууллагын саналыг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангаж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/122 дугаар тушаалаар Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг баталсан.

Жагсаалтын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт ажил олгогчийн мэдлийн байранд хорьсон, эцэг, эхээсээ хол байрлаж, хоноглож ажиллах нөхцөл үүсгэсэн, ажлын байрнаас гадуур бусадтай харилцах боломжгүй байх эсхүл хориглосон, ажил олгогч нь хүүхдийн баримт бичгийг барьцаалсан, бичиг баримтыг нь өөрт нь өгөөгүй, эцэг, эх, харгалзан дэмжигч болон бусад хүмүүсийн өрийн барьцаа, төлөөсөнд ажиллуулсан, ямар нэгэн хариуцлага хүлээлгэхээр айлган сүрдүүлсэн, залилсан, хуурч мэхлэх замаар ажиллуулсныг хүүхдийн хөдөлмөрт албадлага, хүч хэрэглэсэнд тооцохоор заажээ¹¹.

11 <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532151428791&showType=1>

Зураг 4. Хүүхдийн ёс суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх ажил

Хүүхдийн ёс суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх ажил



Зураг 5. Хүүхдийг хүчирхийлэлд өртүүлэх магадлалтай ажил

Хүүхдийн хүчирхийлэлд өртүүлэх магадлалтай ажил



Энэхүү жагсаалтаар насанд хүрээгүй хүнийг 10 салбар, 5 дэд салбарт 101 ажлын байранд ажиллуулахыг хоригложээ.



Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар баталсан.

Хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсноор Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэг /Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг/, Арван дөрөвдүгээр бүлгийн 14.1 дүгээр зүйл /Ялгаварлан гадуурхах/, Арван зургаадугаар бүлэг /Хүүхдийн эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан; Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хохирогч нь 18 насанд хүрээгүй бол түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан бол хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхээр хуульчилжээ.

Тодруулбал, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогч Хууль зүйн туслалцааны төвөөс өмгөөлөл, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах эрх зүйн орчин бүрдсэн байна.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Тухайлбал,

- ✓ Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон төлбөрийн чадваргүй хүн хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах эрх зүйн орчин бүрдсэн;
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийлгэсэн;
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлсэн;
- ✓ Эрүүгийн хуульд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогод тодорхой өөрчлөлт орсон;
- ✓ Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам батлагдсан;
- ✓ Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг баталсан;
- ✓ Нийгмийн хамгааллын салбарын мэргэжилтнүүд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж илрүүлэх зааварчилгаатай болсон гэх мэт.

Гэсэн хэдий боловч өмнө нь хийгдсэн судалгааны тайлангуудад дурдагдсан зарим асуудлууд 2023 оны байдлаар шийдвэрлэгдээгүй хэвээр байна. Тухайлбал,

- ✓ Эрүүгийн хуулийн тусгай ангид хүн худалдаалах гэмт хэргийн хэлбэр бүрийг бие даасан гэмт хэрэг болгосон зохицуулалт хэвээр байгаа боловч тэдгээрийг хэрхэн ялган зүйлчлэх талаар Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар гараагүй;
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам, Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам, Хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах журам, Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журмыг огт шинэчлээгүй, Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам, Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журам огт батлагдаагүй хэвээр байна;
- ✓ Хууль сахиулах, шүүх эрх мэдэл, хил хамгаалах зэрэг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг шууд илрүүлэх боломжтой төрийн албан хаагчдад зориулсан зааварчилга батлагдаагүй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ



**МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН
ХУДАЛДААЛАХ ГЭМТ
ХЭРГИЙН НӨХЦӨЛ
БАЙДАЛ**

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Хүн худалдаалах болон түүнтэй төстэй зарим гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн бүтцэд Хүн худалдаалахтай тэмцэх тасаг, Мөрдөн байцаах албаны бүтцэд Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс ажиллаж, прокурорын байгууллагын хэмжээнд 2020 оноос хойш хүн худалдаалах болон бусад төстэй гэмт хэргийн улмаас хүүхэд хохирсон гэмт хэргийг дагнан хариуцах 49 прокурор хяналт тавин ажиллаж байна.

Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын үнэлгээний тайланг бэлтгэх зорилгоор Улсын ерөнхий прокурорын газраас хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг 2022-2023 оны байдлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйл Бэлгийн мөлжлөг, 13.1 дүгээр зүйл Хүн худалдаалах, 13.13 дугаар зүйл Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргүүдийг хамруулан судаллаа.

Зураг 6. Прокурорын байгууллагын статистик

Прокурорын байгууллагын статистик





Прокурорын байгууллагын статистик мэдээлэлд дурдсанаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах”, 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг”, 13.13 дугаар зүйлд заасан “Албадан хөдөлмөрлүүлэх” нийт 47 гэмт хэрэгт хяналт тавин ажилласан.

Тодруулбал 2021 оны үлдэгдэл 23, 2022 онд бүртгэгдсэн 12, 2023 онд бүртгэгдсэн 12 гэмт хэрэгт хяналт тавьж, хэрэг бүртгэлтийн 11 (23%) хэргийг хааж, 14 (30%) хэрэгт прокурорын яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлж, 2023 оны эцэст хүн худалдаалах 16, бэлгийн мөлжлөгийн 5, албадан хөдөлмөрлүүлэх 1, нийт 22 хэрэг эцэслэн шийдвэрлэгдээгүй буюу мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна.

Хэрэг бүртгэлтийн хэргийг хааж шийдвэрлэсэн үндэслэлийг дүгнэн үзвэл иргэд, төрийн байгууллагаас хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гомдол, мэдээлэл ирүүлснийг мөрдөх байгууллага хүлээн авч, хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж бэхжүүлсэн нотлох баримтуудаар “хүн худалдаалах гэмт хэргийн шинж болох худалдаалах зорилгоор хохирогчийн зорчих эрхийг нь хязгаарлаж, өөрсдийн болон бусдын эрхшээлд бүрэн оруулах, элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах байдлаар бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулсан, боолчилсон, хөдөлмөрийн мөлжлөгт оруулсан гэх, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинж болох хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, аливаа хэлбэрээр эрхшээлдээ оруулах, түүнчлэн эрхшээлдээ байгаа байдлыг нь далимдуулан бэлгийн харьцаанд албадан оруулсан” гэх үйл баримт тогтоогдоогүй бөгөөд тухайн гэмт хэргийн шинжгүй нөхцөл байдал тогтоогдсон тул прокурор мөрдөгчийн гаргасан саналын дагуу хэргийг хааж шийдвэрлэжээ.

Дээрх тохиолдлуудын

- 9 (75%)-д нь Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон” гэж торгох шийтгэл оногдуулсан.

- 1 (8.3)-д нь гадаад улсын иргэн нь цахим хуудсаар харилцан нүцгэн зураг, бичлэгээ явуулж солилцох, чат бичих зэрэг байдлаар олон эмэгтэйчүүдтэй харилцаж байсан боловч тухайн эмэгтэйчүүд нь аль улсын иргэд болохыг тогтоох боломжгүй, мөн тэдэнд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, аливаа хэлбэрээр эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх нөхцөл байдал мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдоогүй тул хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан.

- 1 (8.3)-д нь нь Монгол Улсын иргэн нь БНХАУ-ын Эрээн хотод караокед ажиллах ажлын байранд зуучлах зорилгоор зар байршуулж, зарын дагуу холбогдсон иргэдэд Эрээн хотод очиж ажиллах ажлын талаар танилцуулсан үйл баримт тогтоогдсон нь хүн худалдаалах гэмт хэргийн шинжгүй байна гэж дүгнэн хааж шийдвэрлэжээ.

2022-2023 онд шалгагдсан 47 хэрэгт нийт 47 хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсаны 11 (23.4%)-ийг бэлгийн мөлжлөгийн, 36 (76.6%)-ийг хүн худалдаалах гэмт хэрэгт тус тус яллагдагчаар татаж шалгасан байна.

Прокурорын байгууллагаас 2022 онд хүн худалдаалах 10 хэрэгт 8 хүнийг, бэлгийн мөлжлөгийн 2 хэрэгт 2 хүнийг, 2023 онд хүн худалдаалах 10 хэрэгт 16 хүнийг, бэлгийн мөлжлөгийн 2 хэрэгт 5 хүнийг яллагдагчаар татсан.

Зураг 7. Яллагдагчаар татсан хүний тоо

Яллагдагчаар татагдсан хүний тоо



Харин 2023 онд бүртгэгдсэн албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт тайлант хугацаанд яллагдагчаар татагдах этгээд тогтоогдоогүй байна.

Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан 47 хүний 46.8 хувь нь эмэгтэй, 53.2 хувь нь эрэгтэй бөгөөд тэдний 4.3 хувь нь 16 хүртэл насны, 63.8 хувь нь 17-30 хүртэл насны, 27.7 хувь нь 31-44 насны, 4.3 хувь нь 45-аас дээш настай байна.

Харин боловсролын тухайд бага боловсролтой 3, бүрэн бус дунд боловсролтой 13, бүрэн дунд боловсролтой 26, тусгай дунд боловсролтой 3, дээд боловсролтой 2 хүн байна. Тэдний 16 нь тодорхой мэргэжилтэй бол 42 нь эрхэлсэн тодорхой ажилгүй гэжээ.

Өмнө нь ял шийтгэгдсэн 11 яллагдагчийн тухайд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.6 дугаар зүйлд заасан “Хүний биед хөнгөн хохирол санаатай учруулах” 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах”, 17.2 дугаар зүйлд заасан “Дээрэмдэх” гэмт хэргүүдэд ял шийтгэгдэж байжээ.



Зураг 8. Яллагдагчаар татагдсан этгээдүүдийн насны байдал



Зураг 9. Яллагдагчаар татагдсан хүмүүсийн боловсрол, мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн байдал



Төрсөн эх

Танил

Танихгүй хүн

Яллагдагчаар татагдсан этгээдүүдийн 2 (4.3%) нь хохирогчийн гэр бүлийн хамаарал бүхий хүн болох төрсөн эх, 37 (78.7%) нь танилын харилцаатай, 5 (10.6%) нь танихгүй хүн байна.

Ковид-19 цар тахлаас хойш хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн гаралт гадагшаа чиглэлтэй гэхээсээ илүүтэй дотоодод үйлдэгдэх нь ихсэх хандлагатай байна.

Дотоодод бүртгэгдэж буй хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн дийлэнх нь Улаанбаатар хотод үйлдэгдсэн байна. Тодруулбал 2022, 2023 онд бүртгэгдэж шалгагдсан гэмт хэргийн 2.4 хувь нь орон нутагт, 97.5 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.

Орон нутагт үйлдэгдсэн хэрэг нь олон нийтийн үйлчилгээ явуулдаг газар болох зочид буудалд хоногоор биеийг нь үнэлүүлж үйлдэгдсэн.

Нийслэлд үйлдэгдсэн хэргүүдийн 45.0 хувь нь зочид буудалд, 7.5 хувь нь түрээсийн орон сууц, тусгайлан бэлтгэсэн орон байр, ажлын байранд, 47.5 хувь нь өөрийн, эсхүл үйлчлүүлэгчийн гэрт, автомашинд гэх мэтчилэн бусад газарт үйлдэгджээ.

Тайлант хугацаанд шалгагдсан 3 хэргийг Монгол улсын хилээр нэвтрүүлж үйлджээ.

Хэдийгээр гадаад улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн хэргийн тоо харьцангуй бага байгаа боловч энэ нь эрсдэл арилсан эсхүл эрсдэлгүй болсон гэсэн үг биш юм.

Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментас жил бүр эрхлэн гаргадаг Монгол Улс дахь Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайланд дурдсанаар “Монголын эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хүүхдүүдийг бэлгийн мөлжлөгт ашиглах, албадан хөдөлмөр эрхлүүлэхээр Хятад, Өмнөд Солонгос, Турк болон Ази, Ойрх Дорнодын бусад орнууд болон Америкийн Нэгдсэн Улс руу худалдаж байна. Албан ёсны хүмүүсийн үзэж байгаагаар Монгол Улсын иргэд Турк Улсад визгүй зорчдог, шууд нислэгтэй, цар тахлын улмаас Хятадын хил хааснаар хүмүүсийн аялал, хөдөлгөөний чиглэл өөрчлөгдөн шилжсэнтэй холбогдуулан Бүгд Найрамдах Турк Улс яваандаа хүлээн авагч орон болох магадлал байна”¹² гэжээ.

Гэвч төрийн байгууллагуудын болон иргэний байгууллагуудын мэдээлэлд энэ талаар огт мэдээллээгүй байна.

Цагдаагийн байгууллагын мэдээлэлд дурдсанаар сүүлийн үед цахим орчинд байршуулсан Зүүн Өмнөд Азийн орнуудад “Өндөр цалинтай ажилд авна”, “Хямд зардлаар аялалд зуучилна” гэх зарын дагуу манай улсын иргэд Тайланд, Мьянмар, Камбож, Лаос зэрэг хар тамхи, мансууруулах бодис, биеэ үнэлэлт, цахим луйврын чөлөөт бүс, хууль бус наймааны гол зангилаа “Алтан гурвалжин”-ийн бүс нутагт зорчиж, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн хараа хяналтад орж, гэмт хэрэгт өртөж, хохирох тохиолдол ихэсжээ.

Тодруулбал, 2023 оны байдлаар Гадаад харилцааны яамны Консулын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, НҮБ-ын Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага, Хүйсийн тэгш эрх төв зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 1, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улсаас 10, Тайландын Хаант Улсаас 1, нийт 12 иргэнийг тус тус Монгол Улсад буцаан авчирсан¹³.

12 <https://mn.usembassy.gov/mn/2023-trafficking-in-persons-report-mn/>

13 Гадаад улсаас авчирсан хохирогчид нь бүгд хамгаалах байраар үйлчилгээ авдаггүйг анхаарах хэрэгтэй



Энэ нь 2019-2021 онд гадаад улсаас эх оронд эгүүлэн авчирсан 61¹⁴ хүнээс даруй 5 дахин бага тоо юм. Гэхдээ гадаад улсад хүн худалдаалах гэмт хэрэгт хохирох эрсдэлийг буурсан гэж үзэж болохгүй юм.

Зураг 10. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын байршил

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын байршил



Эх сурвалж: Үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас авсан тоон мэдээлэл, 2024 он

ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны мэдээллээр 2022 онд гадаад улсад хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон хүн бүртгэгдээгүй бол 2023 онд 12 болж өссөн байна. Эдгээр хохирогчид нь бүгд хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирсон байна.

Зураг 11. Гадаад улсад хохирсон хүний тоо

Гадаад улсад хохирсон хүний тоо



14 Хүн худалдаалахтай тэмцэх нөхцөл байдлын тайлан 2019-2021, УБ.,2022.

Тайлант хугацаанд бүртгэгдэж шалгагдсан 47 гэмт хэргийн улмаас нийт 99 хүн хохирсон бөгөөд бүгд Монгол Улсын иргэн байна. Үүнээс 87 (88%-г нь мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгчийн тогтоолоор хохирогчоор тогтоосон.


Нийт 99 хүний 13 (14%) нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг”, 84 (85%) нь 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах”, 1 (1%) нь 13.13 дугаар зүйлд заасан “Албадан хөдөлмөрлүүлэх” гэмт хэргийн улмаас тус тус хохирсон байна.

Нийт хохирогчдын 6.2 хувь нь эрэгтэй, 93.8 хувь нь эмэгтэй, тэдгээрийн 47.5 хувь нь насанд хүрсэн, 52.5 хувь нь насанд хүрээгүй хүн байна.

“Тайлант хугацаанд бага насны 5 хүүхэд хохирсон тохиолдол бүртгэгджээ”


Зураг 12. Хохирогчийн хүйсийн мэдээлэл

Хохирогчийн хүйсийн мэдээлэл



Зураг 13. Хохирогчдын насны байдал


Хохирогчдын насны байдал





Зураг 14. Хохирогчдын боловсролын түвшин

Хохирогчдын боловсролын түвшин



Насанд хүрээгүй хохирогчдын 31 (60%) нь гэр хороололд, 21 (40%) нь нийтийн болон түрээсийн байранд амьдардаг ба 50 (96%) нь эцэг эхийн хараа хяналт сул, архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэлтэй орчинд амьдардаг, 2 (4%) нь хагас бүтэн өнчин, амьдралын боломж тааруу, санхүүгийн хувьд чадамжгүй зэрэг байдлаас шалтгаалан сургуулиас завсардах, ажил хийж цалин авч, санхүүгийн асуудлаа шийдэх сонирхолдоо хөтлөгдөн гэрээсээ дайжин зугтах, бусдад уруу татагдаж, гэмт хэрэгтнүүдэд олзлогдож, гэмт хэргийн хохирогч болжээ.

Харин насанд хүрсэн 47 хохирогчийн 26 (55%) нь гэр хороололд, 21 (44.9%) нь нийтийн болон түрээсийн байранд амьдардаг байжээ.

Дээрх хохирогч нарын хувьд амьдралын боломж тааруу, санхүүгийн хувьд хяз-гаарлагдмал, тодорхой эзэмшсэн мэргэжилгүй, ажилгүй байдлаасаа шалт-гаалан амар хялбар аргаар их хэмжээний мөнгө олж, санхүүгийн асуудлаа түргэн шийдвэрлэх гэсэн хүсэл сонирхолдоо хөтлөгдөн бусдад хууртагдах, бусдын дарамт, заналхийлэл, сүрдүүлэгт өртөх байдлаар гэмт үйл ажиллагаанд нь элсэн орж, улмаар хохирч байгаа нөхцөл байдалтай байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгчөөс нийт 99 хохирогчийн 59 (59.5%)-д нь гэмтлийн зэрэг тогтоох болон бэлгийн харьцаанд орсон ул мөр байгаа эсэхийг тогтоолгохоор шинжилгээ, 39 (39.3%) -д нь сэтгэцийн байдалд шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна.

Насанд хүрсэн хохирогчдын хувьд дийлэнхдээ өөрийн хүслээр амар хялбар аргаар мөнгө олох гэсэн хүсэл сонирхолдоо хөтлөгдөн дээрх төрлийн гэмт хэргийн хохирогч болж байгаа байдал нийтлэг байгаа боловч энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нь гэмт этгээдийн дарамт шахалт, заналхийлэл, айлган сүрдүүлэлтээс үүдэлтэйгээр аливаа хэлбэрээр сэтгэл зүйн гэмтэл авах, бие махбодод нь гэмтэл учрах эрсдэл өндөр байдаг нь судалгаанаас харагдаж байна.

2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж байгаа шинэчлэн батлагдсан Шүүх шинжилгээний тухай хуулийн 39.1 дүгээр зүйлд сэтгэцийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлагыг зааж өгсөн ба мөн зүйлийн 8 дахь хэсэгт "сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох үнэлгээ"-г тогтоох зорилгоор сэтгэцийн шинжилгээг хийлгэх, 40 дүгээр зүйлд "Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэг (Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг), Арван гуравдугаар бүлэг (Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг), 14.1 дүгээр зүйл (Ялгаварлан гадуурхах), ...Арван зургаадугаар бүлэг (Хүүхдийн эсрэг) ...зэрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргахаар заасан¹⁵.

15 Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/268, А/275 дугаар хамтарсан тушаал, Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам

Сэтгэцийн байдалд дүгнэлт гаргуулсан 39 хохирогчийн 10 (25.6%) нь сэтгэцэд учирсан гэмтлийн зэрэглэлийг тогтоолгохоор шинжээч томилж дүгнэлт гаргуулсны 9 (90.0%) хувь нь насанд хүрээгүй хүүхдүүд байгаад бүгдэд “хор уршиг 3 дугаар зэрэглэл”-д байгааг тогтоосон байна.

Дээрх тоо баримтаас үзвэл, хохирогчийн сэтгэцэд учирсан гэмтлийг тогтоолгох ажиллагаа хангалтгүй байгаа нь харагдаж байх ба цаашид мөрдөгч, прокурор дээрх хуулийн зохицуулалтад нийцүүлэн холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулан, нотлох баримтуудыг цуглуулж, шинжээч томилон сэтгэцийн шинжилгээ хийлгэн, дүгнэлт гаргуулж, хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоолгох, цаашилбал сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн сэргээх, сэтгэл заслын эмчилгээнд зарцуулах зардлыг тогтоосон нотлох баримтыг мөрдөн шалгах ажиллагааны явцад заавал хийлгэж хэвших шаардлагатай байна.

Хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад болон прокурорын хяналтын шатанд дээрх төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг мөнгөн илэрхийллээр тогтоож, хохирогчид нөхөн төлүүлсэн тохиолдол байхгүй.

Харин шүүхийн шатанд хэргийг хянан шийдвэрлэх явцад 5 хэргийн 6 шүүгдэгчээс нийт 3,989,068 төгрөгийг гаргуулж, хохирогч нарт олгуулах, насанд хүрээгүй хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлсний төлбөрт “Талита Ази Төв” ТББ-д 4,576,439 төгрөгийг тус тус олгуулахаар, мөн 1 хэргийн 1 шүүгдэгчээс шүүхийн шатанд насанд хүрээгүй хохирогчид учруулсан хохиролд 1,500,000 төгрөг, “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-д үйлчилгээ үзүүлсний төлбөрт 2,440,808 төгрөгийг тус тус төлсөн талаар шийтгэх тогтоолд дурдаж шийдвэрлэсэн байна.

Мөн 4 хэргийн 8 шүүгдэгчээс гэмт хэрэг үйлдэж, хууль бусаар олсон орлого болох нийт 73,251,200 төгрөг, 1 хэргийн 4 шүүгдэгчээс гэмт хэрэг үйлдэхэд ашигласан 3 автомашины үнэ болох нийт 19,000,000 төгрөгийг хувь тэнцүүлэн гаргуулж, тус тус улсын орлого болгохоор шийтгэх тогтоолд дурдаж шийдвэрлэсэн байна.



// Сэтгэцэд учирсан гэмтлийн зэрэглэлийг тогтоолгохоор шинжээч томилж дүгнэлт гаргуулсан 10 хохирогчтой 5 хэргээс 2 хохирогчтой 2 хэргийг шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлсэн байна //

1. Шүүхээс шүүгдэгч М-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад зааснаар “хохирогчийг хүүхэд гэдгийг мэдсээр байж, эмзэг байдлыг нь далимдуулан биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулж хүн худалдаалсан” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, шийтгэх тогтоолд шүүгдэгч М-ээс насанд хүрээгүй хохирогч М-д 1,500,000 төгрөг, “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-д 2,440,808 төгрөг төлсөн болохыг дурдаж шийдвэрлэсэн.




Мөн насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгч нь гэмт хэргийн улмаас насанд хүрээгүй хохирогчид учирсан гэм хортой холбоотой цаашид гарах зардлаа нотлох баримтаа бүрдүүлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу шүүгдэгчээс нэхэмжлэх эрхтэй болохыг дурдаж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч М-ээс гэмт хэрэг үйлдэж олсон орлого болох 2,700,000 төгрөгийг гаргуулж улсын орлого болгохоор шийдвэрлэсэн байна.

- Шүүхээс шүүгдэгч П-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтад зааснаар “Арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг хүч хэрэглэхээр заналхийлж, эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, шүүгдэгч П-ээс хүүхдийн мөнгөн тэтгэмж болох 900,000 төгрөгийг гаргуулж, насанд хүрээгүй хохирогч Б-д олгуулахаар, 4,576,439 төгрөгийг гаргуулж “Талита Ази Төв” ТББ-д олгуулахаар шийдвэрлэсэн.

Мөн насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгч нь насанд хүрээгүй хохирогчид учирсан гэм хорын хохирлын талаарх нотлох баримтыг хуульд заасны дагуу бүрдүүлэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэм буруутай этгээдээс жич нэхэмжлэх эрхтэй талаар шийтгэх тогтоолд дурдаж тус тус шийдвэрлэсэн байна.

Зураг 15. Шүүхэд шилжүүлсэн хэргийн шийдвэрлэлт

Шүүхэд шилжүүлсэн хэргийн шийдвэрлэлт



Шүүхээс оногдуулж буй ял, түүний интервал

Гэмт хэргийн зүйчлэл	Оногдуулж буй ялын доод хэмжээ	Оногдуулж буй ялын дээд хэмжээ	Ялын дундаж
Хүн худалдаалах	2 жил 1 сар	7 жил	5 жил 1 сар
Бэлгийн мөлжлөг	1 жил 1 сар	6 жил 5 сар	5 жил 4 сар

Шүүх хэргийг шийдвэрлэхдээ дээрх хуулийн зохицуулалтыг хэрэглэж байгаа бөгөөд хохирогч өөрт учирсан гэм хорын хохирлын талаарх нотлох баримтыг хуульд заасны дагуу бүрдүүлэн, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэм буруутай этгээдээс нэхэмжлэх эрхийг нь нээлттэй зааж шийдвэрлэжээ.

Судалгааны хамаарах 2 жилийн хугацаанд прокурорын байгууллагаас нэг хэргийн насанд хүрээгүй 2 яллагдагчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, нийт 29 яллагдагчид холбогдох 14 хэргийг шүүхэд шилжүүлсэн байна. Шүүхэд шилжүүлсэн 14 хэргийг шийдвэрлэлтээр нь авч үзвэл, 3 (21%)-г шүүх хянан хэлэлцээгүй, 1 (7%)-д мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, 10 (72%)-г анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоор шийдвэрлэжээ.

Анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн 10 хэргийн 8 (80%) давж заалдах шатны шүүхэд, 1 хэрэг хяналтын шатны шүүхэд хянан хэлэлцэгдсэн.

Анхан шатны шүүхийн шийдвэрийг авч үзвэл, 10 хэргийн 20 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял оногдуулж шийдвэрлэсэн байх ба шүүхээс хэргийг нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр прокурорт буцаасан, шүүгдэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан тохиолдол гараагүй байна.

Шүүхээс оногдуулж буй ялын хэмжээг авч үзвэл, шүүгдэгч нарт 1 жил 1 сараас 7 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 1. Шүүхээс оногдуулж буй ял, түүний интервал

Гэмт хэргийн зүйлчлэл	Оногдуулж буй ялын доод хэмжээ	Оногдуулж буй ялын дээд хэмжээ	Ялын дундаж
Хүн худалдаалах	2 жил 1 сар	7 жил	5 жил 1 сар
Бэлгийн мөлжлөг	1 жил 1 сар	6 жил 5 сар	5 жил 4 сар

Эцэслэн шийдвэрлэсэн дээрх 10 хэргээс 3 хэргийн зүйлчлэлийг шүүх хөнгөрүүлэн өөрчилж, шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3, 3.1 дүгээр зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад зааснаар яллах дүгнэлт үйлдсэн М нарын 2 хүнд холбогдох эрүүгийн хэргийг анхан шатны шүүх хянан хэлэлцээд, "...Бэлгийн мөлжлөг" гэмт хэрэгт хохирогчийг бэлгийн харьцаанд зорчих эрхийг нь хязгаарлахгүйгээр оруулдаг бол "Хүн худалдаалах" гэмт хэргийн явцад хулгайлж, хууран мэхэлж, ... эсхүл хяналтдаа байлгадаг онцлогтой" бөгөөд шүүгдэгч үйлдсэн гэмт хэрэгт "Хүн худалдаалах" гэмт хэргийн шинж байхгүй байх ба тэдний үйлдэл "Бэлгийн мөлжлөг"-ийн гэмт хэргийн шинжийг хангаж байна..." гэж дүгнэн, хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийг журамласныг хөндөлгүйгээр мөн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 2.1 дэх заалтад зааснаар хөнгөрүүлэн зүйлчилж, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 2 жилээс 2 жил 1 сарын хугацаагаар тус тус хорих ял оногдуулж, ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэсэн.



Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 3.1 дэх заалтад зааснаар яллах дүгнэлт үйлдсэн Ө-д холбогдох эрүүгийн хэргийг анхан шатны шүүх хянан хэлэлцээд, "...хэргийн зүйлчлэл тогтоогдсон нөхцөл байдалд тохирохгүй. ...шүүгдэгч нь хохирогч нарыг ашиг олох зорилгоор биеийг нь үнэлүүлж, бусадтай албадан бэлгийн харьцаанд оруулж бусад үйлдэлд "Хүн худалдаалах" гэмт хэргийн шинж тогтоогдохгүй байна" гэж дүгнэн, хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 2.1, 2.5, 2.6 дахь заалтад зааснаар хөнгөрүүлэн, гэм буруутайд тооцож, 5 жилийн хугацаагаар хорих ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэсэн.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 3, 3.1 дүгээр зүйлийн 1, 3.2 дугаар зүйлийн 1, 3.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 2.1, 2.2 дахь заалтад зааснаар яллах дүгнэлт үйлдсэн Н нарын 4 хүнд холбогдох эрүүгийн хэргийг анхан шатны шүүх хянан хэлэлцээд, "...шүүгдэгч нарын үйлдэлд насанд хүрээгүй хохирогч нарын чөлөөтэй зорчих эрх болон бусад эрх чөлөөг хязгаарласан үйлдэл тогтоогдоогүй байна. Шүүгдэгч нарын үйлдэлд "Хүн худалдаалах" гэмт хэргийн шинж байхгүй ба "Бэлгийн мөлжлөг"-ийн гэмт хэргийн шинжтэй байна..." гэж дүгнэн, хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 2.1, 2.5 дахь заалтад зааснаар хөнгөрүүлэн, шүүгдэгч нарыг гэм буруутайд тооцож, Н-д 3 жил, бусад 3 шүүгдэгчид тус бүр 2 жилийн хугацаагаар хорих ялыг нээлттэй хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх прокурорын эсэргүүцлээр 1, хэргийн оролцогч нараас гаргасан гомдлоор 7, нийт 8 хэргийг хянаж шийдвэрлэснээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол гараагүй, харин 3 хэргийн шийтгэх тогтоолд өөрчлөлт оруулсан байна.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүхээс 1 хэргийг прокурорын эсэргүүцэл болон шүүгдэгч нараас гаргасан гомдлоор хянан хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.2 дахь заалтад зааснаар гэм буруутайд тооцож, ял шийтгэсэн Б нарт холбогдох эрүүгийн хэргийг 2023 оны 3 дугаар сард хянан хэлэлцээд, "...анхан болон давж заалдах шатны шүүх хэргийн бодит байдлыг цугларсан нотлох баримтуудад үндэслэн зөв тогтоосон боловч, шүүгдэгч нарын үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах гэмт хэргээр зүйлчилж Эрүүгийн хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна. ...шүүгдэгч нарын үйлдэлд нэр бүхий хохирогч нарын зорчих эрхийг хязгаарлаж, өөрсдийн болон бусдын эрхшээлд бүрэн оруулж, худалдаалах зорилгоор "элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан" гэж дүгнэх хууль зүйн үндэслэлгүй байна..." гэж дүгнэн, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шүүхийн магадлалыг хүчингүй болгож, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт хэргийн зүйлчлэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 2.5, 2.6 дахь заалтад зааснаар хөнгөрүүлэн өөрчилсөн нэмэлт заалт тусгаж, зарим заалтад өөрчлөлт оруулж, шийтгэх тогтоолын бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.

2.2. ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ

Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газартай хамтран 2019-2023 онд “Монгол Улсад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх” төслийг хэрэгжүүлж, үндэсний төслийн хэрэгжүүлэгчээр Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллага ажилласан.

Энэхүү төслийн хүрээнд 2022 онд Хүйсийн тэгш эрх төв ТББ-ын санаачилгаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын алба хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх, тогтоох зааврыг боловсруулан батлуулсан. Тус зааврыг мэргэжлийн бүлгүүдэд таниулах сургалтыг зохион байгуулсан ба нийт 2000 гаруй нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдийг хамруулан сургажээ.

Сургалтад хамрагдсан Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар, Хүүхдийн тусламж утас 108 төвөөс 2022-2023 онд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч ялангуяа насанд хүрээгүй 18 тохиолдлыг дагнасан үйлчилгээний байгууллагууд болох Хүйсийн тэгш эрх төв, Талита-Ази төрийн бус байгууллагад холбон зуучилсан ба тэд хохирогч/үйлчлүүлэгчдийг анхан шатны болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулсан байна.

Улсын хэмжээнд хүн худалдаалахын хохирогчид үйлчилгээ үзүүлж буй Хүйсийн тэгш эрх төв, Талита Ази төрийн бус байгууллагуудад 2022, 2023 онд нийт 146 үйлчлүүлэгч/хохирогч хандсан ба үүнээс 56 хүн буюу 38.35 хувийг насанд хүрээгүй хүн эзэлж байна. Нийт хандсан хохирогчийн 120 буюу 82.2 хувь нь Хүйсийн тэгш эрх төвд, 26 буюу 17.8 хувь нь Талита Азид ханджээ.

Зураг 16. Үйлчилгээ үзүүлж буй байгууллагад хандсан хохирогчийн тоо (хүйсээр)



Эх сурвалж: Үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас ирүүлсэн тоон мэдээлэл, 2024 он

**// Хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн
18 хүн үйлчилгээ авчээ. //**



Үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандсан нийт үйлчлүүлэгчдийг хүйсийн хувьд авч үзвэл 128 нь эмэгтэй, 18 нь эрэгтэй хүн байна. Эрэгтэй үйлчлүүлэгчийн 1 нь Талита Ази төрийн бус байгууллагын урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээд хамрагдаж байсан бол үлдсэн 17 нь Хүйсийн тэгш эрх төвд хандсан бөгөөд эдгээр нь бүгд хүн худалдаалах гэмт хэргийн хөдөлмөр мөлжлөгт өртсөн хохирогч байжээ.

Зураг 17. Мөлжлөгт өртсөн хэлбэр



Эх сурвалж: Үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас ирүүлсэн тоон мэдээлэл, 2024 он

Дээрх судалгаанаас үзвэл бэлгийн мөлжлөгт 117 (80.13%) хүн, хөдөлмөрийн мөлжлөгт 18 (12.32%) хүн өртжээ. Монгол Улсын хувьд хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөгийн хэлбэр илүү үйлдэгдэж байгаа бөгөөд газар зүйн байршлын хувьд улс дотроо буюу дотооддоо үйлдэгдэг байна.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын түр хамгаалах байранд 2022-2023 онд нийт 84 үйлчлүүлэгч байрласан бөгөөд үүнээс 55 (65.47%) нь хүүхэд, 29 нь насанд хүрсэн хүн байлаа. Насанд хүрсэн 29 үйлчлүүлэгч/хохирогч нь бүгд ХТЭТ-ийн хамгаалах байранд байрлажээ.

Зураг 18. Түр хамгаалах байранд байрласан хохирогчдын тоо (2022-2023)



// Түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд дийлэнхдээ 10-29 насны эмэгтэйчүүд хамрагдаж байна. //

Хамгаалах байранд нэг үйлчлүүлэгч дунджаар гурван сараас дээш хугацаанд байрладаг бөгөөд зарим үйлчлүүлэгчдийн хувьд гурваас дээш хугацаанд байрлах хүсэл, сонирхолтой байдаг.

Энэ нь ихэвчлэн гэр бүлдээ эргэн очих хүсэлгүй, эцэг эх нь архины хамааралтай, хүүхдээ анхаарал, халамж тавьдаггүй, эдийн засгийн боломжгүй, гэр бүлийн хүчирхийлэлтэй орчинд амьдардаг гэх зэрэг олон шалтгааны улмаас үргэлжлүүлэн байрлах хүсэлтэй үйлчлүүлэгчид байна.

Тухайлбал, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад 6 сараас дээш хугацаагаар байрлуулж байгаа 20 гаруй насанд хүрээгүй хүүхэд байна.

Тиймээс бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг болон хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч, насанд хүрээгүй хүнийг урт хугацаанд хамгаалан байрлуулах нөхөн сэргээх үйлчилгээ нэн шаардлагатай байгааг харуулж байна.

Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээг байгууллагууд тус бүртээ үйлчилгээ үзүүлдэг бөгөөд бүгд өөр өөрсдийн туршлага дээр үндэслэн үйлчилгээг үзүүлдэг.

Зураг 19. 2022-2023 онд Хүйсийн тэгш эрх төв ТББ-д хандсан үйлчлүүлэгч/хохирогчдод үзүүлсэн үйлчилгээний тоон үзүүлэлт

2022-2023 онд Хүйсийн тэгш эрх төв ТББ-д хандсан үйлчлүүлэгч/хохирогчдод үзүүлсэн үйлчилгээний тоон үзүүлэлт





Зураг 20. 2022-2023 онд Талита Ази-д хандсан үйлчлүүлэгч/хохилогчдод үзүүлсэн үйлчилгээний тоон үзүүлэлт

2022-2023 онд Талита Ази ТББ-д хандсан үйлчлүүлэгч/хохилогчдод үзүүлсэн үйлчилгээний тоон үзүүлэлт



Эх сурвалж: Үйлчлүүлэгч байгууллагаас ирүүлсэн тоон мэдээлэл, 2024 он

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн дагуу Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам батлагдсан тухай өмнөх бүлэгт дурдсан. Энэхүү журам нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулсан.

Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 6.1.1 дэх заалтад "...Эрүүгийн хуулийн Арван зургаадугаар бүлэг /Хүүхдийн эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэргийн арван найман насанд хүрээгүй хохирогч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан", мөн зүйлийн 6.1.2-т "Эрүүгийн хуулийн ...13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хохирогч нь арван найман насанд хүрээгүй бол түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан" тохиолдолд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхээр тодорхойлж өгсөн.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтад зааснаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах эрх зүйн боломжийг бий болгосон. Гэвч энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч авч өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах тохиолдол бага байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлж буй байгууллага болох Хүйсийн тэгш эрх төв, Талита Ази төрийн бус байгууллагуудын мэдээлэлд дурдсанаар нийт үйлчлүүлэгчдийн дийлэнх олонх буюу 90 гаруй хувь нь хууль зүйн туслалцаа дэмжлэгийг авдаг.

Үйлчилгээ үзүүлж буй төрийн бус байгууллагын мэдээллээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандсан үйлчлүүлэгчдийн 133 (91.0%) нь эрх зүйн зөвлөгөө авсан ба үүнээс 51,12 хувь буюу 68 хохирогчдод өмгөөллийн туслалцаа үзүүлсэн байна.

Хүйсийн тэгш эрх төв ТББ насанд хүрсэн болон насанд хүрээгүй хүнд эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг ба хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр дагнан ажилладаг, мэргэшсэн өмгөөлөгчидтэй хамтран ажиллахын зэрэгцээ үйлчилгээний төлбөрт 1,5-3,0 сая төгрөгийг, Талита Ази ТББ хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан үйлчилгээний төлбөрт 3,0- 5,0 сая төгрөгийг зарцуулж байна.

Харин прокурорын байгууллагын мэдээлэлд хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирсон 99 хохирогчийн 39 (39.4%) нь өмгөөлөгчөөр хангагдсан бол, 60 (60.6%) нь өөрийгөө өмгөөлж, мөрдөн шалгах ажиллагаанд оролцсон. Тэр дундаа насанд хүрээгүй 52 хохирогчийн 25 (48.1%) нь өмгөөлөгчөөр хангагдсан, 27 (51.9%) нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцуулаагүй байна.

Цаашид Хууль зүйн туслалцааны тухай болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, мөн судалгаагаар тогтоогдсон дээрх нөхцөл байдалд дүгнэлт хийн, гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл арван найман насанд хүрээгүй бол түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс хүсэлт гаргуулах арга хэмжээг авах, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага болон нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгчээс хохирогчид хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх талаарх хүсэлтийг гаргах, гэмт хэргийн хохирогчид хуулиар олгогдсон өмгөөлөгчөөр хангагдах, өмгөөлүүлэх эрхийг нь эдлүүлэх, өмгөөлөл, хууль зүйн туслалцааг тухай бүр нь үзүүлэх нөхцөлөөр хангаж ажиллахад анхаарах шаардлагатай байна.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлд зааснаар арван найман насанд хүрээгүй хохирогчийн тухайд түүний төрсөн, үрчилж авсан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг, хэрэв дээрх хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохоор заасан.

Хуульд заасны дагуу мөрдөгч, прокурор нь шаардлагатай тохиолдолд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнийг насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоох ажил хэвшсэн байна.

УЕПГ-аас хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг 2022-2023 оны байдлаар судалсан судалгаанд хамрагдсан насанд хүрээгүй 52 хохирогчийн 17 (32.7%) -д тэдний эцэг эх, асран хамгаалагчийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоосон бол, 35 (67.3%) -д харьяа нутаг дэвсгэрийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын¹⁶ мэргэжилтнийг насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож, оролцуулжээ.

16 2023 оны 12 дугаар сараас Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар гэж нэрлэсэн.



Насанд хүрээгүй хохирогч нь өөрийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах чадваргүй тул хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдсон хүн нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлд заасан хохирогчийн хуульд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээдэг учраас маш хариуцлагатай хандах хэрэгтэй байдаг.

Гэвч бодит байдалд насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдсон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүд нь мөрдөн шалгах ажиллагааны явцад насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авах ажиллагаанд болон шүүх хуралдаанд оролцох төдийхнөөр үйл ажиллагаагаа хязгаарладаг, хуульд заасан хохирогчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх ажилд төдийлөн идэвх санаачилгатай хандахгүй, ялангуяа мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргадаггүй, нотлох баримт гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлэх, тусгуулах зэргээр идэвхтэй байр сууринаас хандахгүй тохиолдол цөөнгүй байгаа нь УЕПГ-аас хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг 2022-2023 оны байдлаар судалсан судалгаагаар тогтоогдсон байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт “Засгийн газрын шийдвэрээр хамгаалах байрны үйл ажиллагааг төрийн бус байгууллагад хариуцуулж болно”, мөн зүйлийн 9.4 дэх хэсэгт “Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг Засгийн газар батална” гэж заасан боловч хамгаалах байрны үйлчилгээний зардал, урсгал зардлыг хэрхэн тооцох талаар авч үзээгүй нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлж буй төрийн бус байгууллагуудад төрөөс санхүүгийн дэмжлэг олгогдохгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах төслийн хүрээнд сүүлийн 4 жилийн хугацаанд дээр дурдсан хоёр байгууллагын хамгаалах байрны урсгал зардал болон үйлчилгээ авсан насанд хүрээгүй хохирогчид үзүүлсэн үйлчилгээний зардлыг шийдвэрлэсээр ирсэн.

Өөрөөр хэлбэл уг төслийн хүрээнд 2022, 2023 онд Хүйсийн тэгш эрх төв, Талита Ази ТББ-аар дамжуулан үйлчилгээ авсан 54 хүүхэд үйлчилгээ авснаас 4 нь эрэгтэй, 50 нь эмэгтэй хүүхэд байна. Тэдгээрт үзүүлсэн үйлчилгээтэй холбоотой зардлыг 100 хувь санхүүжүүлсэн байна.

Уг төслийн хүрээнд 2023 оны 10 дугаар сард хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, урт хугацааны нөхөн сэргээх төвийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харьяанд байгуулсан. Тус урт хугацааны нөхөн сэргээх төв нь 10 хүүхдийг зэрэг байршуулах хүчин чадалтай бөгөөд нөхөн сэргээх үйлчилгээ шаардлагатай хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдүүдэд хууль тогтоомж, стандартад нийцүүлэн олон талт мэргэшсэн үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай хамтарч үзүүлдгээрээ онцлогтой юм.

Мөн тайлант хугацаанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарласан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад тэнцсэн Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллагад 60,000,000 (2022 онд 30 сая, 2023 онд 30 сая) төгрөгийн санхүүжилтийг олгож, улмаар хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн 25 хохирогчийг нөхөн сэргээх үйлчилгээнд зарцуулсан байна. Энэ нь хохирогч хамгааллын үйлчилгээнд зарцуулж буй зардалд хангалтгүй юм.

2.3. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас 2023 онд хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс гадна Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад 240,000,000 (хоёр зуун дөчин сая) төгрөг батлагдсаныг дараах үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулжээ. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагад хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд шаардлагатай 76,000,000 (далан зургаан сая) төгрөгийн багаж тоног төхөөрөмж;
2. Хил хамгаалах байгууллагад хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд шаардлагатай 58,000,000 (тавин найман сая) төгрөгийн багаж тоног төхөөрөмж;
3. Шүүх шинжилгээний байгууллагад хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг гэмт хэрэгт шүүхийн шинжилгээ хийхэд шаардлагатай 7,600,000 (долоон сая зургаан зуун мянга) төгрөгийн багаж, тоног төхөөрөмжөөр тус тус хангах;
4. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг олон нийтэд таниулах, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх чиглэлээр 70,000,000 (далан сая) төгрөг;
5. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хамгааллын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг дэмжиж Хүйсийн тэгш эрх төв ТББ-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, 30,000,000 (гучин сая) төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

“Анбаунд Монгол ТББ-аас хил дээрх дамжин өнгөрүүлэх ажиглалтын судалгаагаар хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй 16 тохиолдлыг аргачлалын дагуу тогтоожээ”

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А49 дүгээр тушаалаар Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журмыг баталсан¹⁷. Уг журам нь 18 насанд хүрээгүй Монгол Улсын иргэнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд энэ журмын хэрэгжилтийг Хил хамгаалах байгууллага бусад байгууллагатай хамтран хангаж ажиллахаар зохицуулагджээ.

Хил хамгаалах байгууллагын мэдээллээр 2023 онд Чингис Хаан, Замын-Үүд, Алтанбулаг, Сүхбаатар, Цагааннуур, Эрээнцав, Хавирга боомтоор эцэг, эх хууль ёсны асран хамгаалагчтай 323, тэдгээрээс олгосон итгэмжлэлтэй 1908, цагдаагийн байгууллагын зөвшөөрлөөр олон улсын уралдаан тэмцээнд оролцох зорилгоор 2649, урлаг соёлын болон бусад арга хэмжээнд оролцох зорилгоор 405, сурагч, оюутан солилцоогоор 1144 хүүхдийг тус тус улсын хилээр

¹⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12526>



шалган нэвтрүүлсэн. Харин эцэг, эх хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүйгээр гадаадад зорчихыг завдсан 50 хүүхдийг хил нэвтрүүлэлгүйгээр буцаажээ.

Цагдаагийн байгууллагын мэдээлэлд 2023 онд нийт 348 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, олон улсын уралдаан тэмцээнд эх орноо төлөөлөн оролцох 3546 хүүхдэд тодорхойлолт гарган өгч, хяналт тавин ажилласан.

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Анбаунд Монгол ТББ нь 2022 оны 6 дугаар сарын 20-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарыг дуустал хүн худалдаалах гэмт хэргийн эрсдэл өндөр явах чиглэлийн нислэгүүдэд нийт 232 удаагийн ажиглалтыг хийж 795 зорчигчдод урьдчилан сэргийлэх мэдээлэл өгчээ.

Энэ хугацаанд хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй 16 тохиолдол 52 зорчигчийг (7-31 насны) Анбаунд олон улсын байгууллагын хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлийг таних аргачлалын дагуу тогтоожээ¹⁸.

Мөн байгууллагын хийсэн ажиглалтын үр дүнгээр иргэд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ын талаар мэдээлэлгүй байгаа нь ажиглагдсан байна.

Тайлант хугацаанд Түүнчлэн хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг оновчтой зөв тодорхойлох, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- ✓ Хүн худалдаалах гэмт хэргийн судлагдсан байдлын тойм 2017-2022, УБ.,2023¹⁹;
- ✓ Хүн худалдаалахын төлөв байдал 2017-2021, УБ.,2023²⁰;
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, УБ.,2023²¹;
- ✓ Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, УБ.,2023²²;
- ✓ Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, УБ.,2023²³;
- ✓ Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх байгууллагын чадавх, албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох үнэлгээний тайлан, УБ.,2022.

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Дэлхийн зөн Монгол ОУБ-аас Монголын сайн дурынхны төв ТББ, Монголын скаутын холбоо ТББ, Лантуун дохио ТББ, Боловсрол ирээдүй хөгжлийн гарц ТББ, Өсвөр үеийнхний

18 Эрсдэл бүхий тохиолдолууд нь ганцаараа эсвэл танихгүй, гадаад хүнтэй зорчиж байгаа, очих газарт нь очих газрынхаа талаар тодорхой мэдээлэлгүй, эргэлзсэн, хэн нэгний эрхшээлд орсон зэрэг шинж тэмдгүүд ажиглагдсан.

19 <https://cccp.gov.mn/newsm/252/297>

20 <https://cccp.gov.mn/newsm/252/251>

21 <https://stoptrafficking.mn/product/319289>


22 <https://cccp.gov.mn/newsm/252/209>

23 <https://stoptrafficking.mn/product/293062>

хөгжлийн төв ТББ-тай хамтран нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүрэгт 2022 оны 01 дүгээр сараас эхлэн “Гэрээр айлчлагч хөтөлбөр”²⁴-ийг хэрэгжүүлж байна.

Зураг 21. Гэрээр айлчлагч хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талууд

Гэрээр айлчлагч хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талууд




Зураг 22. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Нийслэлд үйлдэгдсэн хэргүүдийн



Орон нутагт үйлдэгдсэн хэрэг нь олон нийтийн үйлчилгээ явуулдаг газар болох зочид буудалд хоногоор биеийг нь үнэлүүлж үйлдэгдсэн.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн



24 Гэрээр айлчлагч хөтөлбөр нь хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх хөтөлбөр бөгөөд хүчирхийлэл, дарамт, мөлжлөгт өртөх өндөр эрсдэлд амьдарч байгаа хүүхдээ хамгаалан халамжлахад гэр бүлийг нь чадавхжуулах зорилготой олон улсын аргачлал юм.



Гэрээр айлчлагч хөтөлбөрийн хүрээнд 220 гаруй сайн дурын ажилтан ажиллаж, зорилтот 1000 өрхийн 2000 гаруй хүүхдэд туслах зорилгоор сард 1-2 удаа гэрээр нь айлчилж, нийт 357 удаагийн холбон зуучлах үйлчилгээг хүүхдүүд ба гэр бүлд хүргэжээ.

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн гишүүн байгууллагуудаас хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий 21 видео, 79 постер, 28 даван туулагчийн түүх нийтлэл, 21 нийтлэл, 105 инфографикыг нийтэд түгээжээ.

Зураг 23. Хөх зүрхний аян болон Мэддэг мэдээлдэг байя аян



НҮБ-аас жил бүрийн 7 дугаар сарын 30-ны өдрийг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх дэлхийн өдөр болгон тэмдэглэж “Хөх зүрхний аян”-ыг зохион байгуулдаг бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд аяны хүрээнд 7 хоногийн турш олон нийтэд чиглэсэн хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, мэдээллийг цахим орчинд түгээж хэвшсэн байна.

Харин Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, олон нийтийн, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, эрсдэлтэй тохиолдлыг мэдээлдэг, эрсдэл өндөр хүүхэд, хохирогчийг илрүүлэх, тэднийг үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандуулах, хамгаалах хандлагыг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Мэддэг, мэдээлдэг байя” аяныг 2023 оноос зохион байгуулжээ. Аяны нэгдүгээр үе шат 2023 оны 09 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулагдсан.

“Мэддэг мэдээлдэг байя” аяны өмнөх болон дараах судалгааг Y-Insight байгууллагаас явуулсан. Хоёр удаагийн харьцуулсан судалгааны үр дүнгээр хөдөлмөрийн мөлжлөгийн талаар мэддэг гэж хариулсан иргэдийн тоо эхний шатны судалгаанаас 11% өсөж 48%-д, бэлгийн мөлжлөгийн талаар мэддэг гэж хариулсан иргэдийн тоо өмнөх судалгаанаас 20% өсөж 49%-д, ХХГХ-ийн талаар мэдлэг өмнөх судалгаанаас 15% өсөж 46%-д хүрчээ.

Аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэг чиглэл нь тухайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг төрийн, иргэний нийгмийн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах явдал юм.



// Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх, ажиллагаа сургалтын өмнөх мэдлэг 58.6% байсан бол сургалтын дараах үр дүн 74.9% болж өсжээ. //

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022, 2023 онд зохион байгуулсан сургалтын талаарх мэдээллийг нэгтгэн авч үзвэл:

1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа» нэг өдрийн сургалтад ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хэлтсийн 19, Шүүх шинжилгээний ерөнхий газрын 21, Хууль зүйн туслалцааны төвийн 71, Хүний эрхийн үндэсний комиссын 36, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 28, Хил хамгаалах ерөнхий газрын 12, нийт 187 албан хаагч;
2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа» улсын хэмжээнд зохион байгуулсан сургалтад 21 аймаг, 9 дүүргийн 135 шүүгч, 169 прокурор, 481 цагдаагийн албан хаагч, нийт 785 албан хаагч;
3. Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн сэтгэцийн гэмтлийг бууруулах, дахин сэдрээхгүй байх, мөрдөн шалгах ажиллагаанд хүүхдэд ээлтэй, хохирогч төвтэй хандлагаар ярилцах Форензик ярилцлага хийх сургалтад 20 мөрдөгч, прокурор;
4. Монгол Улсаас гадаад улсад суух элчин сайдын яам, консулын газарт шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан хүн худалдаалах гэмт хэрэг гэж юуг ойлгох, хэрхэн хохирогчийг таньж илрүүлэх, ярилцлага хийх арга зүй, тус гэмт хэргийн хохирогчийг хамгаалж, туслалцаа үзүүлэхэд консулын ажилтны үүрэг хариуцлага зэрэг мэдлэг, ойлголт эзэмшүүлэх сургалтад 25 улс, 35 хотод суух 81 консулын ажилтан;



5. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд урлагаар сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх чадвар эзэмшүүлэх зорилгоор зохион байгуулсан сургалтад Донбоско МСҮТ, Монголын хүүхдийн сан, Шинэ найдвар, Манай гэр, Альфа коммюнитиз, Бадамлянхуа хүүхдийн төв, Хүүхдийн төв сувилал, Вербист, Гэрэл, Цөлийн сарнай, Улаанбаатар СОС Хүүхдийн хотхон, Манаа хүүхдийн асрамж, халамжийн төв, Өнөр бүл хүүхдийн төв, Кристина Нархан төв, Эрдэм төв газрууд, Хүүхдийн тусламжийн утас 108, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Чингэлтэй, Хан-Уул, Сүхбаатар, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн НЦҮТ, ТХБ, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс, ЦЕГ, Талита Ази ТББ, Хүйсийн тэгш эрх төв ТББ, Анбаунд Монгол ТББ, Өсвөр үеийнхний хөгжлийн төв ТББ, Хөөрхөн зүрх ТББ-ын 85 албан хаагч, мэргэжилтэн;
6. Хүн худалдаалах гэмт хэргийн гэрч хохирогч хүүхдэд сэтгэлзүйн зөвлөгөө тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтад Цагдаагийн ерөнхий газрын харьяа нэгжүүд, Дотоодын цэргийн штаб, Өнөр бүл хүүхдийн төв, Хүүхдийн тусламжийн утас 108, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр, Баянхонгор, Дархан, Сайншанд, Завхан, Орхон, Өвөрхангай, Хэнтий, Сэлэнгэ аймгийн түр хамгаалах байр, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ын дэргэдэх түр хамгаалах байрны 28 ажилтан, албан хаагч;
7. Хүүхдийн хөдөлмөрийн чиглэлээр хөдөлмөрийн болон хүүхдийн эрхийн улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтад 21 аймаг, 9 дүүргийн хөдөлмөрийн байцаагч 64, хүүхдийн эрхийн улсын байцаагч 55, нийт 119 албан хаагч;
8. Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим сургалтад Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын худалдаа аж үйлдвэрийн тэнхим, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, болон бусад хүүхэд хамгааллын төрийн болон ТББ-ын мэргэжилтэн 112 хүнийг сургагч багшаар бэлтгэж, сургалтад Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Булган, Орхон, Говьсүмбэр, Багахангай, Архангай аймгийн бизнесийн байгууллага болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 659 хүн;
9. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг таньж илрүүлэх холбон зуучлах мэдлэг, чадвар эзэмшүүлэх зорилгоор зохион байгуулсан сургалтад Эх нялхсын эрүүл мэндийн үндэсний төв, Өргөө амаржих газар, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Налайх, Багануур дүүргийн эрүүл мэндийн төв, Грандмед эмнэлэг, Мэри Стоп эмнэлэг, Нийслэлийн эрүүл мэндийн газар, 21 аймгийн эх барих эмэгтэйчүүдийн чиглэлийн 121 эмч, Хүүхдийн тусламжийн 108, түр хамгаалах байрны 31 ажилтан, Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн гэрээр айлчлагч болон сайн дурын 240 ажилтан, нийт 392 ажилтан, албан хаагч;
10. Хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдлэг ойлголт эзэмшүүлэх зорилгоор Өсвөрийн клубийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд уг сургалтад Ухаалаг хөтөч 40 клуб, Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой 26 клуб, Цахим орчин дах хүүхдийн аюулгүй байдал 16 клуб, Ухаалаг хөтөч болон Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой клубийн хамтад нь хэрэгжүүлдэг 19 клубийн 2200 сурагч;
11. Гэрээр айлчлагч хөтөлбөрийн хүрээнд “Сайн дурынхантай ажиллах арга барил ба зарчим” сургалтад 30, хүн худалдаалах гэмт хэргийн ерөнхий ойлголт мэдлэг өгөх сургалтад 43, бэлгийн хүчирхийлэл мөлжлөгийн талаарх ойлголт өгөх сургалтад 15, Хүүхэд хамгааллын сургалтад 221, нийт 309 албан хаагч ажилтан тус тус хамрагджээ.

2.4.ХАМТЫН АЖИЛЛАГАА

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл нь улсын хэмжээнд хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулах, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэйгээр ажилладаг.

Монгол Улс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, төрийн бусад байгууллага болон олон улсын байгууллагуудтай нягт уялдаатай ажиллажээ.

Зураг 24. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд

Олон улсын төсөл хөтөлбөр

АНУ-ын Төрийн департаментын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” төсөл

БНСУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх” төсөл

Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь цахим хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах ур чадварыг бэхжүүлэх нь” төсөл

Нидерланд Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь” төсөл

АНУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас хэрэгжүүлж буй Албадан хөдөлмөрөөс сэргийлэх, тэмцэх нь” төсөл

НҮБ-ын Итгэлцлийн Сангийн дэмжлэгтэйгээр Японы Хүүхдийг Ивээх Сангийн хэрэгжүүлсэн “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төсөл

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төсөл

Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Төрийн департамент хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийг 2020 оноос эхлэх хэрэгжүүлж байна.

Төслийн хэрэгжилтэд Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Улсын ерөнхий прокурорын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас хяналт тавьж, ерөнхий удирдлагаар ханган, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж, төслийг Азийн сан олон улсын байгууллага, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын хамтарсан консорциум хэрэгжүүлж байна.



Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг тогтмолжуулан хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- ✓ “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах төслийн хэрэгжилтийн явц байдалд дүн шинжилгээ хийх, танилцах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл солилцох хоёр улсын Засгийн газрын дээд хэмжээний уулзалтыг жил бүр зохион байгуулдаг;
- ✓ Салбар дундын хамтарсан багийн үйл ажиллагаа жилээр төлөвлөн хэрэгжүүлж, багийн гишүүдийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр менторшип хөтөлбөрийг хэрэгжүүлдэг;
- ✓ Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг асуудал, шийдэл хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулдаг;
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагаас гадна хил хамгаалах, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, хөдөлмөр, авто болон агаарын тээврийн салбарын албан хаагч, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулсан;
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох;
- ✓ Урьдчилан сэргийлэх чиглэлээр, сургуульд суурилсан өсвөр үеийнхэнд зориулсан хөтөлбөрүүд, зорилтот хороодод сайн дурын ажилтнуудаар дамжуулан мэдээлэл түгээх, хил дээр дамжин өнгөрөх ажиглалт, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, хамгаалах байрны үйл ажиллагааг бэхжүүлэх, хүүхдийн эрхийн болон хөдөлмөрийн улсын байцаагчдыг чадваржуулах;
- ✓ Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж буй зарим байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлэх;
- ✓ Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлэхийн тулд богино болон урт хугацааны хамгаалах байруудад техникийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг тодорхой, үр дүнтэй ажлууд хийгдсэн байна.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх төсөл

БНСУ-ын Жендэрийн тэгш эрх, гэр бүлийн яамны дэмжлэгтэйгээр “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх” төслийг 2019 оноос эхлэн 5 жилийн хугацаатай хэрэгжүүлж дуссан. Төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ерөнхий удирдлагаар хангаж Хүйсийн тэгш эрх төв ТББ гүйцэтгэсэн байна.

Төслийн хүрээнд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх замаар холбогдох бодлого, хөтөлбөрт нөлөөлөх, хэрэгжилтэд олон талт оролцоог нэмэгдүүлэн ажилласан.

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр Монгол Улс анх удаа Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх зааврыг боловсруулан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлуулан анхан шатны нэгжид ажиллаж буй хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарынхан ашиглаж байна.

“Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь” төсөл

Нидерландын улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр 2019 оноос хойш 3,5 жилийн хугацаанд «Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь» төслийг НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага хэрэгжүүлжээ.

Төслийн хүрээнд дараах онцлог үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ✓ Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааг анх удаа хийсэн;
- ✓ Хууль сахиулах, шүүх эрх мэдлийн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчид, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх;
- ✓ Хөдөлмөр зуучлалын байгууллагын ажилтнуудад ёс зүйтэй хөдөлмөр зуучлалын талаарх чадавхжуулах сургалт;
- ✓ Мөрөөдлийн шүхэр 1, 2 мэдээллийн аян болон гадаадад цагаачлах хүсэлтэй иргэдэд зориулсан ОУШХБ-ын хөгжүүлсэн Миг Апп системийг монгол дээр ашиглах боломжийг бий болгожээ.

“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төсөл

Хүүхдийг Ивээх Сан нь Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглалын хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын Итгэлцлийн Сан болон Японы Хүүхдийг Ивээх Сангийн хамтран санхүүжүүлсэн “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг 2021-2024 оны хооронд хэрэгжүүллээ. Төслийн зорилго нь Улаанбаатар хотын 5 дүүргийн 12-18 насны охидыг хүчирхийлэл, мөлжлөгт өртөх эрсдэлээс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах, сэтгэцийн гэмтэлд суурилсан даван туулагчид ээлтэй үйлчилгээний арга зүйг нэвтрүүлэхэд чиглэсэн. Төслийн хүрээнд

- ✓ 2022 онд төслийн баг, эрдэмтэн судлаачидтай хамтран Хүүхэд хамгааллын чадавхжуулах 11 модуль багц гарын авлагыг боловсруулж, гарын авлагын дагуу чадавх бэхжүүлэх 544 цагийн сургалт зохион байгуулж, үүнд дан тоогоор 926, давхардсан тоогоор 1415 мэргэжилтэн, үйлчилгээ үзүүлэгч, алба хаагчийг хамруулсан.
- ✓ Нийслэлийн Ерөнхий боловсролын 15 сургууль дээр урьдчилан сэргийлэх 4 том, 60 жижиг хэмжээний нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, давхардсан тоогоор нийт 25,834 сурагч, 1,112 багш, ажилтан, 3,318 эцэг эх асран хамгаалагчид хүрсэн.



- ✓ Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилготой “Чи ганцаараа биш” 3 үе шаттай нөлөөллийн ажил болон “MEWE” нөлөөллийн ажлууд хэрэгжүүлж, давхардсан тоогоор 40 орчим сая хандалттай байв.
- ✓ Төслийн суурь судалгаанаас эхлээд Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний стандартыг үнэлэх үнэлгээ, Нөхцөл байдлын үнэлгээ, Хүүхэд хамгааллын талаарх насанд хүрэгчдийн мэдлэг, хандлага, дадлын судалгаа, Хүүхэд хамгааллын мэдээллийн системийн үнэлгээ болон Барианы судалгаа, Хүүхдийн эрхийн мэдрэмжтэй сэтгүүл зүй гарын авлага, Нийгмийн ажилтнуудад зориулсан супервишн хийх гарын авлага, Охидын дэвтэр зэрэг гарын авлага боловсруулжээ.

НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын Хөгжлийн сангийн санхүүжилтээр 1 жилийн хугацаатай “Монгол Улс дахь цахим хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах ур чадварыг бэхжүүлэх нь” техникийн туслалцааны төслийг 2023 оны 07 дугаар сараас, АНУ-ын Хөдөлмөрийн яамны дэмжлэгтэйгээр Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас хэрэгжүүлж буй Албадан хөдөлмөрөөс сэргийлэх, тэмцэх БРИЖ-II» төслийг мөн 2023 оны 07 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж эхэлжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанаас 2023 оны 06 дугаар сард Хүн худалдаалах үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн талаар Ази, Номхон далайн бүс нутгийн бодлого боловсруулдаг Бали процесс (Bali process)-ын Ажлын албаны төлөөлөлтэй цахим уулзалт зохион байгуулж, Зүүн Өмнөд Азийн улс оронд Монгол Улсын иргэд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болж буй нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцож, хамтын ажиллагааг өргөжүүлэх, Зүүн Өмнөд Азийн улс орнуудын хууль сахиулах байгууллагуудтай харилцаа, холбоо тогтоон ажиллаж байна.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Нэг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

Хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль, тэдгээрийг дагаж гарсан хэм хэмжээний актын хүрээнд явагдаж байна.

2022, 2023 онд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх нийт 99 хохирогч, 47 холбогдогчтой 47 гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, 14 хэргийг шүүхэд шилжүүлэн, 11 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж шийдвэрлэсэн бөгөөд 2023 оны эцэст 52 хохирогчтой, 16 холбогдогчтой, 22 хэргийн үлдэгдэлтэй байжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах”, 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг”, 13.13 дугаар зүйлд заасан “Албадан хөдөлмөрлүүлэх” гэмт хэрэг 2022 онд шинээр 12 бүртгэгдэж байсан бол 2023 онд шинээр 12 бүртгэгдсэн байна. Нийт 24 гэмт хэрэгт 45 хүн хохирогчоор тогтоогдсоноос 36 (80) нь насанд хүрээгүй хүн байна. Хэдийгээр гэмт хэргийн гаралт өсөх явдал харьцангуй бага байгаа ч энэ төрлийн гэмт хэрэгт насанд хүрээгүй хүмүүс өртөх явдал өссөөр байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад прокуророос хэргийн зүйлчлэл өөрчлөөгүй нь мөрдөгч, прокурорын энэ төрлийн гэмт хэргийн талаарх ойлголттой болж эрүүгийн эрх зүйн зохицуулалтын талаарх нэг мөр нэгдсэн ойлголтод хүрсэнтэй холбоотой гэж судлаачид дүгнэж байна.

Харин шүүхэд шилжүүлсэн хэргээс 3 хэргийн зүйлчлэлийг “...эсхүл хяналтдаа байлгадаг онцлогтой, ...шүүгдэгч нь хохирогч нарыг ашиг олох зорилгоор биеийг нь үнэлүүлж, бусадтай албадан бэлгийн харьцаанд оруулж бусад үйлдэлд хүн худалдаалах гэмт хэргийн шинж тогтоогдохгүй байна, ...шүүгдэгч нарын үйлдэлд насанд хүрээгүй хохирогч нарын чөлөөтэй зорчих эрх болон бусад эрх чөлөөг хязгаарласан үйлдэл тогтоогдоогүй зэрэг үндэслэлээр өөрчилсөн нь хууль зүйн үндэслэлгүй байна.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд “... эсхүл хяналтдаа байлгах” гэсэн шинж байхгүй бөгөөд гэмт этгээд хохирогчийг бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртүүлж, биеийг нь үнэлүүлж, ашиг олдог онцлогтой. Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон Палермо протоколын агуулгад хүүхдийн биеийг нь үнэлүүлсэн, бэлгийн мөлжлөгт өртүүлсэн, боолчилсон, албадан хөдөлмөрлүүлсэн бол тухайн үйлдлийг ямар аргаар үйлдсэн байх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй байх зохицуулалт бий. Энэ нь мөн манай Эрүүгийн хуульд ч тусгалаа олсон.

Иймээс өмнөх бүлгийн дүгнэлтэд дурдсан Улсын дээд шүүхээс Эрүүгийн хууль дахь хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн шинжийг ялган зүйлчлэхтэй холбоотой тайлбарыг яаралтай хийх нь чухал байна.



Мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчийн сэтгэцэд учирсан гэмтлийг тогтоолгох эрх зүйн орчин бүрдэж, хууль сахиулах байгууллага тодорхой төрлийн гэмт хэрэгт шинжээч томилон сэтгэцийн шинжилгээ хийлгэн, дүгнэлт гаргуулж байна. Тайлант хугацаанд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон 39 хүнд сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ хийлгэснээс 9 нь хүүхэд байжээ.

Цаашид сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн сэргээх, сэтгэл заслын эмчилгээнд зарцуулах зардлыг тогтоосон нотлох баримтыг мөрдөн шалгах ажиллагааны явцад заавал хийлгэж хэвших шаардлагатай.

Тайлант хугацаанд Монгол Улсын 16 иргэнийг гадаад улсад худалдаалж, бэлгийн мөлжлөгт өртүүлсэн тохиолдол бүртгэгдсэн бол гадаад улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон 12 иргэнийг эгүүлэн авчирчээ.

Хоёр. Хохирогч хамгаалал

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хуульд заасан хамгааллын үйлчилгээ болон бусад нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлснээр ахин энэ төрлийн гэмт хэрэгт өртөх, өөрсдөө энэ төрлийн гэмт хэрэг үйлдэх эрсдэлээс хамгаалах чухал ач холбогдолтой.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зааснаар энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид түр хамгаалан байрлуулах, эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах зэрэг үйлчилгээг үзүүлэхээр хуульчилсан.

Хэдийгээр мөрдөн шалгах байгууллагад 99 хүн хохирогчоор тогтоогдсон гэсэн байгаа боловч энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчдыг хамгаалах чиглэлээр үйлчилгээ үзүүлдэг Хүйсийн тэгш эрх төв ТББ болон Талита Ази ТББ-аас нийт 146 хүн үйлчилгээ авсан байна. Өөрөөр хэлбэл хууль сахиулах байгууллагад хандаагүй ч хамгааллын болон бусад үйлчилгээ авсан 47 хүн байна.

Өмнөх тайланд дурдсанаар 2019-2021 онд албадан хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн хохирогч байхгүй байсан бол 2022-2023 онд 18 хүн хөдөлмөрийн мөлжлөгт өртөж, үйлчилгээ авчээ. Гэвч эдгээрээс аль нь хууль сахиулах байгууллагад хандаагүй байна.

Үйлчилгээ үзүүлж буй ТББ-уудын мэдээллээр үйлчлүүлэгчдийн 133 (91.0%) нь өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авсан бөгөөд өмгөөллийн үйл ажиллагаанд 1,5-5,0 сая төгрөгийн зардал гаргаж байна гэжээ. Гэвч прокурорын байгууллагын мэдээлэлд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн улмаас хохирсон 99 хүний 39 (39.4%) нь өмгөөлөгчөөр хангагдсан бол, 60 (60.6%) нь өөрийгөө өмгөөлж, мөрдөн шалгах ажиллагаанд оролцжээ.

Иймээс Хууль зүйн туслалцааны тухай болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, мөн судалгаагаар тогтоогдсон дээрх нөхцөл байдалд дүгнэлт хийн, гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл арван найман насанд хүрээгүй бол түүний эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс хүсэлт гаргуулах арга хэмжээг авах, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага болон нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгчээс хохирогчид хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх талаарх хүсэлтийг гаргах, гэмт хэргийн хохирогчид хуулиар олгогдсон өмгөөлөгчөөр хангагдах, өмгөөлүүлэх эрхийг нь эдлүүлэх, өмгөөлөл, хууль зүйн туслалцааг тухай бүр нь үзүүлэх нөхцөлөөр хангаж ажиллахад анхаарах шаардлагатай байна.

Насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нэгэн чухал асуудал нь хууль ёсны төлөөлөгчийг томилох асуудал юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлд зааснаар 18 насанд хүрээгүй хохирогчийн тухайд түүний төрсөн, үрчилж авсан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг, хэрэв дээрх хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохоор заасан.

Хуульд заасны дагуу мөрдөгч, прокурор нь шаардлагатай тохиолдолд Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын байгууллагын мэргэжилтнийг насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоох ажил хэвшсэн байна.

Улсын ерөнхий прокурорын газраас хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг 2022-2023 оны байдлаар судалсан судалгааны дүнд хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдсон Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын байгууллагын мэргэжилтнүүд нь мөрдөн шалгах ажиллагааны явцад насанд хүрээгүй хохирогчоос мэдүүлэг авах ажиллагаанд болон шүүх хуралдаанд оролцох төдийхнөөр үйл ажиллагаагаа хязгаарладаг, хуульд заасан хохирогчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх ажилд төдийлөн идэвх санаачилгатай хандахгүй, ялангуяа мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргадаггүй, нотлох баримт гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлэх, тусгуулах зэргээр идэвхтэй байр сууринаас хандахгүй тохиолдол цөөнгүй байгаа нь дээр дурдсан судалгаагаар тогтоогдсон байна гэжээ.

Иймээс насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдон оролцож байгаа мэргэжилтэн нь мөрдөн шалгах ажиллагаанд идэвхтэй байр сууринаас оролцож, насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны эрх ашгийг бодитой хамгаалж ажиллахад анхаарах шаардлагатай байна.

Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хохирогч хамгааллын үйлчилгээтэй холбоотой санхүүжилттэй холбоотой асуудал анхаарал татсан хэвээр байна. Учир нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хохирогч хамгааллын үйлчилгээ нь төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээс өөр санхүүжилтгүй байгаа талаар мэдээлжээ.

Иймд хохирогч хамгаалалтай холбоотой үйлчилгээний зардал, санхүүжилтийг улсын төсвөөс гаргуулах боломжит эрх зүйн орчин, түүний хийдлийг арилгах, сайжруулах чиглэлээр анхаарах шаардлагатай байна.



Гурав. Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагаа

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үүрэг хүлээсэн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр аян, төлөвлөгөөт арга хэмжээг авч хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрсэн байна. Гэвч эдгээр аян, арга хэмжээ нь нэг удаагийн шинжтэй, тодорхой хугацаанд өрнөөд дуусаж байгаа нь анхаарал татаж байна.

Иймээс цаашид энэ чиглэлээр зохион байгуулж буй аян, арга хэмжээг цаг хугацаа, орон зайд баригдалгүйгээр, нэгдсэн төлөвлөлттэйгөөр хэрэгжүүлэх нь чухал байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх заалтад зааснаар Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа хүүхдийн биеийн байцаалтыг тодруулах, итгэмжлэлийн үндсэн дээр бусдын хүүхдийг харгалзан яваа этгээдийн биеийн байцаалт, ямар зорилгоор хүүхдийг дагуулан явж байгаа, тухайн хүүхэдтэй ямар холбоотой болох, хүлээн авагч гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг шалгаж нягтлах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/49 дүгээр тушаалаар батлагдсан “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам”-ын хэрэгжилтэд Хил хамгаалах байгууллага хяналт тавьж, хэрэгжүүлэх үүрэг хүлээж байна.

Хил хамгаалах байгууллагын мэдээллээр жилд дунджаар 2000-3000 хүүхэд олон улсын уралдаан тэмцээнд оролцох зорилгоор цагдаагийн байгууллагын зөвшөөрлийн бичиг баримттайгаар улсын хилээр нэвтэрч байна.

Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд Чингис хаан ОУНБ, Замын-Үүд боомтод дамжин өнгөрөх ажиглалтын судалгааг хийж буй Анбаунд Монгол ТББ-ын ажиглалтын судалгааны үр дүнд иргэд дээр дурдсан журмын талаар мэдээлэлгүй байгаа нь ажиглагдсан байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн талаар иргэд, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, өсвөр үеийнхнийг энэ төрлийн гэмт хэргээс өөрийгөө болон бусдыгаа хамгаалах дадал эзэмшүүлэх зорилгоор Ухаалаг хөтөч, Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой, Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал клубийг нийслэлийн ерөнхий боловсролын болон МСҮТ-дэд байгуулсан, хүчирхийлэл, дарамт, мөлжлөгт өртөх өндөр эрсдэлд амьдарч байгаа хүүхдээ хамгаалан халамжлахад гэр бүлийг нь чадавхжуулах зорилготой “Гэрээр айлчлагч хөтөлбөр” олон улсын аргачлалыг нэвтрүүлсэн нь сайшаалтай байна.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэг чиглэл нь тухайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг төрийн, иргэний нийгмийн байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах явдал юм. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн хүрээнд “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сургалтыг 2023 онд улс даяар зохион байгуулж, нийт 972 шүүгч, прокурор, мөрдөгч, албан хаагч, мэргэжилтнүүдийг хамруулсан.

Энэхүү сургалтын өмнө авсан сорилоор хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт мэдлэг 58.6 хувь байсан бол сургалтын дараах үр дүнгээр 74.9 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь улсын хэмжээнд хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэйгээр ажилладаг.

Монгол Улс 2022, 2023 онд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 6 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлжээ (зураг 26-г үзэх).

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн байгууллагуудын үйл ажиллагаагаа нэгдсэн удирдлага, зохион байгуулалтгүй бөгөөд хамтдаа хэрэгжүүлэх явдал дутмаг байгаа нь харагдаж байна.



ЗӨВЛӨМЖ

1. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах;
2. Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах, 12.3 дугаар зүйлд заасан Бэлгийн мөлжлөг, 13.3 дугаар зүйлд заасан Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн шинж, ялган зүйлчлэх талаар Улсын дээд шүүхийн тайлбар гаргуулах;
3. 2023 оны байдлаар батлагдаагүй болон шинэчлэн боловсруулаагүй байгаа Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам, Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ хийх журам, Хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах журам, Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журмын шинэчилсэн найруулга, Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам, Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг боловсруулж батлуулах;
4. Хууль сахиулах, шүүх эрх мэдэл, хил хамгаалах зэрэг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг шууд илрүүлэх боломжтой төрийн албан хаагчдад зориулсан зааварчилгаатай болох;
5. Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;
6. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулж буй сургалтыг цаашид тогтмол ашиглах боломжийг нэмэгдүүлж, цахим хичээл хэлбэрээр бэлтгэж, холбогдох системд байршуулах;
7. Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй аян, нэгдсэн арга хэмжээг тогтвортой бөгөөд урт хугацаанд хэрэгжүүлэх;
8. Олон улсын төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад бий болсон сайн туршлагыг цаашид тогтвортойгоор ашиглах, үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд анхаарах;
9. Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлж буй байгууллагын үйл ажиллагааг төрөөс дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх.

